



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС**

2018 ОНЫ ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН АЖЛЫН ТАЙЛАН

2018 ОН

1. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖИЛ

- Мэдээ тайлангийн гаргалт, түүний бодит байдал, бүртгэл, тооллого, судалгааны чвц, үр дүнд хийсэн хяналт, шалгалт
- Хагас жилийн малын түүвэр судалгааны хяналт шалгалт / 2018 он 6, 11, 12 сар /

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2018 оын үйл ажиллагааны төлөвлөгөө, аймгийн Засаг даргын 2018 оны А/183 тоот захирамжийн дагуу малын хагас жилийн түүвэр судалгаа явагдсан. Статистикийн хэлтсийн даргын удирдамжийн дагуу аймгийн ажлын хэсэг 6 дугаар сарын 11-ээс 13-ны өдрүүдэд Сүхбаатар, Зүүнбүрэн, Сайхан, Сант, Орхон сумдад хяналтын тооллого хийлээ.

Ажлын хэсгийн гишүүд:

1. Сэлэнгэ аймгийн Статистикийн хэлтсийн дарга Д.Гүндэгмаа
2. Сэлэнгэ аймгийн ХХААГ-ын дарга Х.Мөнхтөр
3. Сэлэнгэ аймгийн Татварын хэлтсийн дарга Х.Батболд
4. Сэлэнгэ аймгийн НДХэлтсийн дарга С.Отгонжаргал
5. Сэлэнгэ аймгийн Статистикийн хэлтсийн мэргэжилтэн Х.Батбаатар нар ажиллалаа.

Хяналтаар дээрх сумдын нийт 50 өрхөөр орж, тооллогын материалын дүнд тулгалт хийлээ. Малын хагас жилийн түүвэр судалгаагаар сумдад ажиллаж байгаа ажлын хэсгийн гишүүд судалгаанд хамрагдсан айл өрхөд, судалгаанд хамрагдсаныг нотлох цоохрыг Сүхбаатар, Зүүнбүрэн, Сант сумууд үлдээсэн, Сайхан, Орхон сумдууд үлдээгээгүй байсан ба дээрх сумдад гарсан зөрчлийг газар дээр нь арилгуулж ажлын хэсгийн гишүүдэд заавар зөвлөгөөг өгч ажиллалаа.


Малчид зусландаа буусантай холбоотойгоор шатахууны зардал хүрэлцэхгүй хүндрэл гарсан байна.





Аймгийн Засаг даргын 2018 оны А/424 дугаар захирамжийн аймгийн мал тооллогын ажлын хэсэг Шаамар, Сант, Баруунбүрэн, Орхонтуул, Хушаат, Мандал, Баянгол гэсэн 7 суманд жилийн эцсийн мал тэжээвэр, амьтад, хашаа, худгийн хяналтын тооллогыг хийхээр бэлтгэл ажлыг хангасан. Мөн ҮСХ-ноос хяналтын тооллогын ажлын хэсэг гарч дээрх сумдаас Шаамар, Сант, Баруунбүрэн, Хушаат чиглэлд аймгийн ажлын хэсэгтэй хамтран 2018 оны 12 сарын 10-14-ний өдрүүдэд ажиллалаа.

Дээрх сумдад аймгийн Засаг даргын захирамжийн дагуу сумын Засаг даргын орлогчоор ахлуулсан 6-7 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулж, Засаг даргын захирамж гарган 2018 оны мал тэжээвэр амьтдын тооллогыг зохион байгуулан явуулж байна. Сумдууд айл өрхийн малыг тоолж цоохор хуудас олгон ажилласан Хушаат сумын хувьд ААНБ-ын малыг тоолсон цоохор хуудас олгоогүй байна



Тооллогод хамрагдсан өрхүүд өвөлжилтийн бэлтгэлээ сайтар хангасан байгаа нь харагдаж байлаа. Тус сумдад нийт адуу 435 толгой, үхэр 608 толгой, хонь 2672 толгой, ямаа 1809 толгой бүгд 5524 толгой мал хяналтаар тооллоо.

Сумдад ажиллахдаа сумын мал тооллогын ажлын хэсэгтэй уулзаж, ажлын явцтай танилцан, жилийн эцсийн мал тооллогын зарим нэг анхаарах асуудалд заавар, зөвлөгөө өгч ажиллалаа.

Шаамар суманд хяналтын тооллогын явцад дараах зөрчил илэрч, илэрсэн зөрчлийг ажлын хэсэгт танилцуулж залруулсан болно. Үүнд:

Мал тооллогын маягтын худаг, усан сан, малын хашаа хэсгийн мэдээллийг буруу нөхсөн.



- **Статистикийн анхан шатны мэдээ тайлан гаргалт, үнэн бодит байдал, сар улирлын мэдээний архивлалт, хадгалалт дээр шалгалт хийж, заавар зөвлөгөө өгч ажиллалаа:**


Сэлэнгэ аймгийн Статистикийн хэлтсээс 2018 оны хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөний дагуу түүвэрлэгдсэн сумдад 2018 оны 06, 11, 12 дугаар саруудад 2016, 2017, 2018 онуудын статистикийн анхан шатны мэдээ тайлан гаргалт,

баримтжуулалт, үнэн бодит байдал, статистикийн мэдээлэл тархаалт, мэдээ дамжуулалт, сар улирлын мэдээний архивлалт, хадгалалт, File хэлбэрийн мэдээллийн эмх цэгц дээр хяналт, шалгалт хийж, заавар зөвлөгөө өгч ажиллалаа

Хамарсан хүрээ

- Хөдөө аж ахуйн тасаг
 - Багийн Засаг дарга нар
 - Статистик мэдээ хариуцсан ажилтан
 - Анхдагч мэдээ мэдээлэл өгч буй түүвэр судалгаанд сонгогдсон ААНБ, өрх
- Хийсэн ажил:**
- 2015-2018 оны статистик мэдээ архивлалт, баталгаажуулсан гарын үсэг, тамга тэмдгийн бүрэн байдал.
 - Статистик мэдээллийн тархаалт, хэрэглэгчдэд зориулсан сургалт, статистикийн тухай хуулийг хэрэгжүүлж байгаа үйл явц, ажил үүргийн уялдаа холбоо.
 - Анхдагч мэдээлэл өгч буй ААНБ, өрхүүдийг мэдээнд хамруулж буй байдал
 - Албан ёсны статистикийн мэдээний маягтыг хэрхэн бөглөх, мэдээг ямар хугацаанд хэрхэн дамжуулах талаар

Сант сум



Орхон сумын Статистик хариуцсан мэргэжилтэн Уянга



Сайхан сумын Статистик хариуцсан мэргэжилтэн Шинэцэцэг



Мөн Цемент шохойн үйлдвэр ХК, Хөтөл бейкери ХХК, Хөтөлжимсгэнэ ХХК зэрэг ААНБ-уудаар орж мэдээний тулгалт хийж ажиллалаа.

Сүхбаатар сум



Дүгнэлт

Статистикийн хэлтсийн дотоод хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөний дагуу сумдад ажиллалаа. Мөн хяналтаар аймгийн Засаг даргын 2017 оны “ Анхан шатны статистик мэдээ, тайлангийн чанар, үр нөлөөг сайжруулах тухай ” 05 тоот албан даалгаврын биелэлтийг үзлээ. Үүнд:

1. Сурталчилгаа, мэдээлэл тархаалтын хувьд статистикийн тухай хууль, дүрэм, журмыг мэдээллийн самбар дээр байршуулсан боловч нийгэм, эдийн засгийн шаардлагатай тоон мэдээлэл байхгүй, мэдээллийн самбарыг тогтмол баяжуулан шинэчлэлт хийдэггүй.
2. Статистик мэдээ, тайланг графикт хугацаанд аж ахуй нэгж байгууллагуудаас цуглуулан авч байгаа боловч мэдээний алдаа дутагдлыг хянаж шалгалгүй шууд илгээж, дамжуулагчийн үүрэг гүйцэтгэн ажиллаж байна.
3. Анхдагч нэгжээс авсан мэдээ, тайланг сумын статистик хариуцсан ажилтан давхар хянаж өмнөх сар, улирал, жилийн мэдээтэй уялдуулан гарсан алдаа бүрийг тухай бүр нь ААНБ-аар засуулж байх.
4. Багийн Засаг дарга нартай хамтран ажиллаж хүн ам, өрхийн мэдээллийн сан, хөдөө аж ахуйн мэдээллийн сангуудын мэдээллийн үнэн бодит байдлыг шалгах, баяжилт хийх, гарсан алдааг бууруулах шаардлагатай байна.
5. Архив, бичиг хэргийн стандартыг дагаж мөрдөх шаардлагатай байна. Үүнд: архивласан материалыг үзэхэд ноорог цаасан дээр хэвлэсэн, хаягжилт дутуу, хуудсын тоо дугаарлаагүй, түр болон байнга хадгалах нэгж үүсгээгүй, архивласан материал нь төрөлжүүлээгүй бүх салбарын бичиг баримттай холилдсон.

Иймд дээрх илэрсэн алдаа дутагдлыг засч залруулах тал дээр заавар зөвлөмж өгч ажиллалаа.

- ❖ Судалгааны үнэн бодит байдлыг хангах зорилгоор судалгааны ахлагч зарим нэгжид биечлэн болон зайнаас хяналт хийлээ. Үүнд: Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаанд Сүхбаатар, Ерөө, Шаамар, Жавхлант, Мандал, Сант, Баруунбүрэн, Орхонтуул, Сайхан, Алтанбулаг, Цагааннуур сумын 42 өрхөд өрхөд зайнаас болон биечлэн, ажиллах хүчний судалгаанд 30 өрхөд зайнаас болон биечлэн очиж хяналт хийж ажиллалаа. Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа, ажиллах хүчний судалгааны хяналтаар Сайхан, Сант сумдад ажиллалаа.



**БОЛОВСРОЛ, СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР, ЭРҮҮЛ МЭНДИЙН
ГАЗАР, СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ХАМТАРСАН
ХЯНАЛТ – ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2018 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/372 дугаар захирамжийн дагуу хяналт-шинжилгээ үнэлгээний ажлыг Статистикийн хэлтсийн дарга, улсын байцаагч Д.Гүндэгмаа, ахлах мэргэжилтэн, улсын байцаагч Ч.Цэнд-Аюуш, Эрүүл мэндийн газрын хяналт-шинжилгээ үнэлгээ мониторингийн хэлтсийн мэргэжилтэн Д.Буяндэлгэр, Боловсрол, соёл, урлагийн газрын статистик, хяналт – шинжилгээ үнэлгээний мэргэжилтэн Э.Долгормаа нар хамтран Монгол улсын “Статистикийн тухай” хуулийн хэрэгжилтийг хангах, гарч болзошгүй эрсдэл, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, анхан шатнаас цуглуулж байгаа болон тооллого, анхдагч мэдээллийн чанарт тавих нэгжийн дотоод хяналтыг сайжруулах, үр нөлөөг дээшлүүлэх, ингэснээр анхан шатны болон тооллого, судалгааны анхдагч мэдээллийн чанарыг улам сайжруулах зорилгоор Сүхбаатар, Алтанбулаг, Мандал, Баянгол, Баруунбүрэн сумын сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төв, сумын ЗДТГазар дээр ажиллалаа.

Хамарсан хүрээ:

- Сүхбаатар сумын 4-р сургууль, 1-р сургууль, 3-р цэцэрлэг, 4-р цэцэрлэг
- Алтанбулаг сумын ЗДТГазар, 12 жилийн дунд сургууль, Найрамдал 1-р цэцэрлэг, Эрүүл мэндийн төв
- Баянгол сумын ЗДТГазар, 12 жилийн дунд сургууль, Солонго цэцэрлэг, Эрүүл мэндийн төв
- Мандал сумын ЗДТГазар, 4-р сургууль, 3-р сургууль, 1-р сургууль, Нархан цэцэрлэг, 1-р цэцэрлэг, Эрүүл мэндийн төв
- Баруунбүрэн сумын эрүүл мэндийн төв

Алтанбулаг сумын төрийн сангийн мэргэжилтэн, багийн Засаг дарга нарын ажлыг шалгасан хяналт, шалгалтын ажлын тайлан

Тус сумын төрийн сангийн мэргэжилтэн Э.Цэнд-Аюуш, багийн Засаг дарга Г.Жамбалдорж нартай хамтран ажиллалаа. Статистикийн анхан шатны мэдээ тайлан гаргалт түүнд тавьж буй хяналт, алдаа түүний залруулалт, статистик мэдээ түүний баримтжуулалт, үнэн бодит байдал, статистикийн мэдээ мэдээлэл тархаалт, мэдээ дамжуулалт сар улирлын мэдээний архивлалт, хадгалалт дээр хяналт, шалгалт хийж заавар зөвлөгөө өгч ажиллалаа. Үүнд:

- 2017, 2018 оны статистик мэдээг үзэхэд мэдээ эмх цэгц муутай замбараагүй, мэдээ тус бүр мэдээний хавтасгүй, мэдээ баталгаажуулалт тамга, гарын үсэг дутуу байсан.
- Статистик мэдээний архивлалтын хаягжуулалтыг бичээгүй, 2017 оны малын “А” дансыг үдэж архивлаагүй байв.
- Статистик мэдээллийн тархаалт дээр хангалтгүй байлаа.



Баянгол сумын төрийн сангийн мэргэжилтэн, багийн Засаг дарга нарын ажлыг шалгасан хяналт, шалгалтын ажлын тайлан


Тус сумын төрийн сангийн мэргэжилтэн Г.Баясгалан, 1-р багийн Засаг дарга Л.Занданбат, 2-р багийн Засаг дарга Б.Түшигжаргал, 3-р багийн Засаг дарга Б.Болортуяа нартай хамтран ажиллалаа.

- Статистик мэдээг харахад мэдээний хавтасгүй, 2017 оны хөдөө аж ахуйн мэдээг үдээгүй, аж ахуйн нэгж, байгууллагаас авсан мэдээний зарим нь тамга, гарын үсгээр баталгаажуулаагүй
- Статистик мэдээний архивлалтын хаягжуулалтыг бичээгүй, 2015, 2016, 2017 оны хамтад үдсэн байна. Мэдээ тус бүрээр, он оноор нь салгаж үдээгүй байв.
- Мэдээний үндсэн маягт буюу нэг хувийг нь сумандаа авч үлдээгүй аймгийн статистикийн хэлтэст явуулсан байна. 1-р багийн Засаг дарга 2017 оны малын “ А “ дансыг үдэж цэгцлээгүй байна.
- Статистик мэдээллийн тархаалт сайн байлаа.



Мандал сумын эдийн засагчийн ажлыг шалгасан хяналт, шалгалтын
ажлын тайлан

Мандал сумын эдийн засагч Д.Эрдэнэбаяртай хамтран ажиллав.




- 2017 он, 2018 оны Статистик мэдээний архивлалтын хаягжуулалт, мэдээ баталгаажуулсан гарын үсэг, тамга тэмдгийн бүрэн байдал сайн байв.
- Статистик мэдээллийн тархаалт дээр статистикийн самбар байршуулан эдийн засгийн ерөнхий үзүүлэлт, хүн ам зүйн мэдээлэл, сарын танилцуулга, инфог байршуулсан байна.
- Статистик мэдээний батлагдсан маягтан дээр хэрхэн ажиллах хэрхэн бөглөх, мэдээ мэдээлэл дамжуулах хугацаанд цахим хэлбэрээр болон маягтаар илгээх тал дээр заавар зөвлөмж өгч ажилласан.

**Сүхбаатар сумын ерөнхий боловсролын лаборатори
4 дүгээр сургуульд хийсэн хяналт шинжилгээ
үнэлгээний ажлын тайлан**

2018-2019 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын лаборатори 4 дүгээр сургууль нь 32 бүлгийн 932 суралцагчтай 2 ээлжээр хичээллэж нийт 63 удирдах ажилтан, багш, бусад ажилтан ажиллаж байна. 2018 оны 11 дүгээр сарын 12 –ны өдөр сургуулийн дунд ангийн сургалтын менежер Д.Алтанцэцэг, бага ангийн сургалтын менежер Л.Оюунтүлхүүр нартай хамтран ажилаллаа.

Уг сургуулийн албан бичиг хэргийн хөтлөлт эмх цэгцтэй, бүртгэлийн номер дугаар зөрсөн, давхардсан зүйл байхгүй, статистик мэдээ цаасаар хэвлэж гаргасан аймгийн нэгтгэлтэй тулгаж үзэхэд ямар нэгэн зөрүүтэй тоо илрээгүй. Сургуулийн мэдээ мэдээллийн самбарт энэ хичээлийн жилийн статистик мэдээнд үндэслэн иргэдэд зориулсан зарим тоон мэдээллийг тодорхой хэмжээнд нээлттэй ил тод байсан мөн багшийн журнал хөтлөлт сайн байгаа нь сайшаалтай байна.



Боловсролын салбарын мэдээллийн системийн бүртгэлийн хүрээнд:



Суралцагчдын холбоо барих утас, гэрийн хаяг, өрхийн мэдээлэл, дүрэмт хувцас, сурах бичиг амьдрах орчин оруулсан боловч баримт бичиг, мэдээллийн шинчлэлтийг хийгээгүй байна. Мөн бага боловсрол эзэмшиж байгаа хүүхдийн эрүүл мэндийн

мэдээллийг оруулсан боловч дунд анги болон ахлах ангийн суралцагчдын эрүүл мэндийн мэдээлэл оруулаагүй байна. Ажилтны хүрээнд анхан шатны бүртгэлийн ихэнд мэдээллийг оруулсан боловч гэрийн хаяг болон эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамрагдсан байдлыг оруулаагүй орхигдуулсан байна.

Байгууллагын хүрээнд хичээлийн байр болон өрөө анги танхим оруулсан. сургуулийн нэгшил буюутусгай зөвшөөрөл дээрх нэр мэдээллийн системийн нэртэй таарч байна.

Цаашид сайжруулах зүйлс :

- Суралцагчдын баримт бичиг, эрүүл мэндийн мэдээллийг БСМС-д оруулах
- Ажилтнуудын эрүүл мэндийн мэдээлэл болон гэрийн хаягыг БСМС-д оруулах

Санал хүсэлт:

- Статистик мэдээ гаргаж байгаа буюу сургалтын менежерүүдийн компьютерийн үзүүлэлт, интернетийн хурдыг сайжруулах шаардлагатай байна.
- Ирц, үнэлгээ, хичээлийн сэдэв, ээлжит хичээлүүдийг БСМС-д оруулдаг болсонтой холбогдуулан багш, сургалтын менежерүүдийн ажлын ачаалал маш их нэмэгдэж байна. Энэ ачааллыг багасгах тал дээр статистик хариуцсан ажилтан эсвэл хүний нөөцийн ажилтантай болох саналтай байна.
- Сургуулийн бичиг хэргийн ажилнуудад албан бичиг хэргийн хөтлөлт, стандартын сургалтад суух хүсэлтэй байна.

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуульд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний ажлын тайлан

2018-2019 оны хичээлийн жилд сүхбаатар сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 45 бүлгийн 1333 суралцагчтай 2 ээлжээр хичээллэж нийт 108 удирдах ажилтан, багш, бусад ажилтан ажиллаж байна. Статистик мэдээнд 69 суралцагч дотуур байранд амьдарч байгаагаар өгсөн бол яг өрөөдийн байдлаар 74 хүүхэд дотуур байранд сууж байна.



2018 оны 11 дүгээр сарын 12 –ны өдөр тус сургуулийн захирал Ц.Рэнцэнноров, сургалтын менежер Н.Дэлгэрцэцэг нартай хамтран ажиллалаа.

Уг сургуулийн албан бичиг хэргийн хөтлөлт эмх цэгцтэй, бүртгэлийн номер дугаар зөрсөн, давхардсан зүйл байхгүй, статистик мэдээ цаасаар хэвлэж гаргасан аймгийн нэгтгэлтэй тулгаж үзэхэд ямар нэгэн зөрүүтэй тоо илрээгүй. Сургуулийн мэдээ мэдээллийн самбарт энэ хичээлийн жилийн статистик мэдээнд үндэслэн бүлгийн тоон мэдээллийг тодорхой хэмжээнд нээлттэй ил тод байлгасан байна. Үүнийг хийхдээ бүлэг дүүргэлтийг хувиар илэрхийлсэн нь илүү ойлгомжтой харагдаж байна.

Боловсролын салбарын мэдээллийн системийн бүртгэлийн хүрээнд:

Суралцагчдын дүрэмт хувцас, амьдрах орчин оруулсан боловч баримт бичиг, холбоо барих утас, гэрийн хаяг, эрүүл мэнд, сурах бичиг, мэдээллийн шинчлэлтийг хийгээгүй байна. Харин суралцагчдын зураг оруулсан нь сайшаалтай байна.



Ажилтны хүрээнд анхан шатны

бүртгэлийн ихэнд мэдээллийг оруулсан боловч гэр бүлийн мэдээлэл, гэрийн хаяг оруулаагүй байна. Сургуулийн нийт ажилтан нэгдсэн журмаар эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамрагдаагүй байна.

Байгууллагын хүрээнд хичээлийн байр болон өрөө анги танхим оруулсан. сургуулийн нэгшил буюу тусгай зөвшөөрөл дээрх нэр мэдээллийн системийн нэртэй таарч байна.

Цаашид сайжруулах зүйлс :

- Суралцагчдын холбоо барих утас, гэрийн хаяг, сурах бичиг, баримт бичиг, эрүүл мэндийн мэдээллийг БСМС-д оруулах
- Ажилтнуудын гэр бүлийн мэдээлэл болон гэрийн хаяг, ажлын түүхийг Б

- СМС-д оруулах

Санал хүсэлт:

- Статистик мэдээ гаргаж байгаа буюу сургалтын менежерүүдийн компьютерийн үзүүлэлт, интернетийн хурдыг сайжруулах шаардлагатай байна.
- Ирц, үнэлгээ, хичээлийн сэдэв, ээлжит хичээлүүдийг БСМС-д оруулдаг болсонтой холбогдуулан багш, сургалтын менежерүүдийн ажлын ачаалал маш их нэмэгдэж байна. Энэ ачааллыг багасгах хүсэлтэй байна.
- Нийт ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоонд хамруулах саналтай байна.
-

Сүхбаатар сумын 3 дугаар цэцэрлэгт хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний ажлын тайлан



2018-2019 оны хичээлийн жилд Сүхбаатар сумын 3 дугаар цэцэрлэг нь 16 бүлгийн 452 хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж нийт 64 удирдах ажилтан, багш, бусад ажилтан ажиллаж байна.

2018 оны 11 дүгээр сарын 13 –ны өдөр тус цэцэрлэгийн эрхлэгч П.Амарсанаа, арга зүйч З.Гэрэлтнاران нартай хамтран ажиллалаа. Статистик

мэдээ цаасаар хэвлэж гаргасан аймгийн нэгтгэлтэй тулгаж үзэхэд ямар нэгэн зөрүүтэй тоо илрээгүй. цэцэрлэгийн мэдээ мэдээллийн самбарт энэ хичээлийн жилийн статистик мэдээг тавьсан байна.

Ажиллагчдын хувийн хэргийн хавтас нэгэн жигд, материал бүрдүүлэлт хангалттай сайн байна. Харин албан бичиг хэргийн хөтлөлт (ирсэн, явсан) бичгийн бүртгэл эмх цэгц муутай, бүртгэлийн карт хөтлөлт байхгүй байна.

Боловсролын салбарын мэдээллийн системийн бүртгэлийн хүрээнд:

Хүүхдийн холбоо барих утас, гэрийн хаяг, амьдрах орчинг оруулсан байна. Харин суралцагчдын зураг оруулаагүй байна.

Ажилтны хүрээнд анхан шатны бүртгэлийн ихэнд мэдээллийг оруулсан боловч зураг оруулаагүй байна.

Байгууллагын хүрээнд цэцэрлэгийн байр болон өрөө анги танхим оруулсан байна. БСМС-ийн бүртгэл хөтлөлт маш сайн



хийгдсэн нь сайшаалтай байна.

Цаашид сайжруулах зүйлс :

- БСМС-д бүртгэлтэй бүх хүний зураг оруулах
- Ирсэн, явсан бичгийн бүртгэл сайн хөтлөж бүртгэлийн карт хөтлөх шаардлагатай
- БСМС-д ирцийн бүртгэл үнэн зөв оруулах өөрөөр хэлбэл багшийн хөтлөж буй цаасан журналын ирц бүртгэл БСМС-ийн ирц бүртгэлтэй таарах ёстой.

Санал хүсэлт:

- Шилжилт хөдөлгөөн хийсэн суралцагчийгөөр аймаг, хотын цэцэрлэг хасалт түргэн шийдвэрлэж байх
- Хүүхэдтэй ажиллах цаг зав хомс бөгөөд олон програм дээр ижил төрлийн мэдээлэл шивж байгааг болиулах
- Компьютер болон интернэт орчин бүрдүүлж өгөх
-

**Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэгт хийсэн хяналт шинжилгээ
үнэлгээний ажлын тайлан**

2018-2019 оны хичээлийн жилд Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэг нь 9 бүлгийн 271 хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж нийт 33 удирдах ажилтан, багш, бусад ажилтан ажиллаж байна. Статистик мэдээ цаасаар хэвлэж гаргасан аймгийн нэгтгэлтэй тулгаж үзэхэд ямар нэгэн зөрүүтэй тоо илрээгүй. цэцэрлэгийн мэдээ мэдээллийн самбарт энэ хичээлийн жилийн статистик мэдээг тавьсан байна. Албан бичиг хэргийн хөтлөлт (ирсэн, явсан) бичгийн бүртгэл хөтлөлт сайн байна.



Боловсролын салбарын мэдээллийн системийн бүртгэлийн хүрээнд:

Хүүхдийн холбоо барих утас, гэрийн хаяг, амьдрах орчин оруулсан байна. Харин суралцагчдын зураг оруулаагүй байна. Ажилтны хүрээнд анхан шатны бүртгэлийн ихэнд мэдээллийг оруулсан боловч зураг, баримт бичиг оруулаагүй байна. Байгууллагын хүрээнд цэцэрлэгийн байр болон өрөө анги танхим оруулсан байна. БСМС-ийн бүртгэл хөтлөлт маш сайн хийгдсэн нь сайшаалтай байна.

Цаашид сайжруулах зүйлс :

- БСМС-д бүртгэлтэй бүх хүний зураг оруулах

Санал хүсэлт:

- Шилжилт хөдөлгөөн хийсэн суралцагчий гөөр аймаг, хотын цэцэрлэг хасалтыг түргэн шийдвэрлэж байх
- Хүүхэдтэй ажиллах цаг зав хомс бөгөөд олон програм дээр ижил төрлийн мэдээлэл шивж байгааг болиулах
- Архив, бичиг хэргийн сургалтад хамрагдах саналтай байна.

Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургуульд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний ажлын тайлан

2018-2019 оны хичээлийн жилд Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургууль нь 28 бүлгийн 761 суралцагчтай 2 ээлжээр хичээллэж нийт 59 удирдах ажилтан, багш, бусад ажилтан ажиллаж байна. 2018 оны 12 дугаар сарын 04 –ны өдөр Сургуулийн захирал Б.Эрдэнэочир, дунд ангийн сургалтын менежер Л.Өлзийцэнгэл нартай хамтран ажиллалаа.




Уг сургуулийн статистик мэдээ цаасаар хэвлэж гаргасан аймгийн нэгтгэлтэй тулгаж үзэхэд ямар нэгэн зөрүүтэй тоо илрээгүй. Сургуулийн мэдээ мэдээллийн самбарт энэ хичээлийн жилийн статистик мэдээнд үндэслэн иргэдэд зориулсан зарим тоон мэдээллийг сонирхолтой байдлаар, тодорхой хэмжээнд нээлттэй ил тод байсан мөн багшийн журнал хөтлөлт сайн байгаа нь сайшаалтай байна.



Боловсролын салбарын мэдээллийн системийн бүртгэлийн хүрээнд:

Суралцагчдын холбоо барих утас, гэрийн хаяг, өрхийн мэдээлэл, дүрэмт хувцас, сурах бичиг амьдрах орчин, баримт бичиг, эрүүл мэнд оруулсан бөгөөд бүртгэлийг бүрэн оруулсан гэж үзэж байна.



Ажилтны хүрээнд анхан шатны бүртгэлийн ихэнд мэдээллийг оруулсан боловч баримт бичиг болон эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамрагдсан байдлыг оруулаагүй орхигдуулсан байна.

Байгууллагын хүрээнд хичээлийн байр болон өрөө анги танхим оруулсан. сургуулийн нэгшил буюу тусгай зөвшөөрөл дээрх нэр мэдээллийн системийн нэртэй таарч байна.

Цаашид сайжруулах зүйлс :

- Ажилтнуудын эрүүл мэндийн мэдээлэл болон баримт бичгийг БСМС-д оруулах

Санал хүсэлт:

- Интернэтийн хурдыг сайжруулах шаардлагатай байна.

Алтанбулаг сумын цэцэрлэгт хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний ажлын тайлан

2018-2019 оны хичээлийн жилд Алтанбулаг сумын найрамдал 1-р цэцэрлэг нь 8 бүлгийн 215 хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж нийт 25 удирдах ажилтан, багш, бусад ажилтан ажиллаж байна.



2018 оны 12 дугаар сарын 04–ны өдөр тус арга зүйч К.Эрдэнэбилэгтэй хамтран ажиллалаа.

Статистик мэдээ цаасаар хэвлэж гаргасан аймгийн нэгтгэлтэй тулгаж үзэхэд ямар нэгэн зөрүүтэй тоо илрээгүй. Ажиллагчдын хувийн хэргийн хавтас нэгэн жигд, материал бүрдүүлэлт хангалттай сайн байна. Харин албан бичиг хэргийн хөтлөлт (ирсэн, явсан) бичгийн бүртгэлийн карт хөтлөх шаардлагатай байна. Цэцэрлэгийн арга зүйч статистик мэдээний зарим үзүүлэлтээр судалгаа хийж ажилладаг нь харагдаж байна.

Боловсролын салбарын мэдээллийн системийн бүртгэлийн хүрээнд:

Хүүхдийн холбоо барих утас, гэрийн хаяг, амьдрах орчин оруулсан байна. Харин суралцагчдын зураг, эрүүл мэндийн үзлэгийн мэдээлэл оруулаагүй байна. Ажилтны хүрээнд анхан шатны бүртгэлийн ихэнд мэдээллийг оруулсан боловч зураг оруулаагүй байна.

Байгууллагын хүрээнд цэцэрлэгийн байр болон өрөө анги танхим бүрэн оруулсан байна.

БСМС-ийн бүртгэл хөтлөлт маш сайн хийгдсэн нь сайшаалтай байна.

Цаашид сайжруулах зүйлс :

- Статистик мэдээний тархаалт хийх
- Ажиллагчдын зураг оруулах шаардлагатай байна.

Санал хүсэлт:

- Шилжилт хөдөлгөөн хийсэн суралцагчийгөөр аймаг, хотын цэцэрлэг хасалт түргэн шийдвэрлэж байх
- Компьютер болон интернэт орчин бүрдүүлж өгөх

Баянгол сумын ерөнхий боловсролын сургуульд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний ажлын тайлан




2018-2019 оны хичээлийн жилд Баянгол сумын ерөнхий боловсролын сургууль нь 32 бүлгийн 889 суралцагчтай 2 ээлжээр хичээллэж нийт 72 удирдах ажилтан, багш, бусад ажилтан ажиллаж байна. 2018 оны 12

дугаар сарын 05 –ны өдөр Сургуулийн захирал Д.Сарангэрэл, дунд ангийн сургалтын менежер Г.Мөнгөнчимэг нартай хамтран ажиллалаа. Уг сургуулийн статистик мэдээ цаасаар хэвлэж гаргасан аймгийн нэгтгэлтэй тулгаж үзэхэд ямар нэгэн зөрүүтэй тоо илрээгүй. Сургуулийн мэдээ мэдээллийн самбарт энэ хичээлийн жилийн статистик мэдээнд үндэслэн иргэдэд зориулсан зарим тоон мэдээллийг сонирхолтой байдлаар, тодорхой хэмжээнд нээлттэй ил тод байсан мөн багшийн журнал хөтлөлт сайн байгаа нь сайшаалтай байна. Сургуулийн сургалтын менежер статистик мэдээний зарим тоон үзүүлэлттэй нэлээн их ажиллаж график болон хүснэгт хийж ажиллаж байгаа нь сайшаалтай байна.

Боловсролын салбарын мэдээллийн системийн бүртгэлийн хүрээнд:

Суралцагчдын зураг, холбоо барих утас, гэрийн хаяг, өрхийн мэдээлэл, дүрэмт хувцас, сурах бичиг амьдрах орчин, баримт бичиг оруулсан боловч эрүүл мэндийг нь оруулаагүй орхигдуулсан байна.



Баянгол сумын ерөнхий боловсролын сургуулийн 2018-2019 оны хичээлийн жилд	
Суралцагчдын тоо	889
Багш, ажилтан	72
Бусад ажилтан	...
Хичээлийн жилд	...
Мэдээллийн системийн бүртгэл	...
Хүснэгт	...
График	...
Холбоо барих утас	...
Гэрийн хаяг	...
Өрхийн мэдээлэл	...
Дүрэмт хувцас	...
Сурах бичиг	...
Амьдрах орчин	...
Баримт бичиг	...
Оруулсан боловч эрүүл мэндийг нь оруулаагүй	...

Ажилтны хүрээнд анхан шатны бүртгэлийн ихэнд мэдээллийг оруулсан боловч эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамрагдсан байдлыг оруулаагүй орхигдуулсан байна.

Байгууллагын хүрээнд хичээлийн байр болон өрөө анги танхим оруулсан. сургуулийн нэгшил буюу тусгай зөвшөөрөл дээрх нэр мэдээллийн системийн нэртэй таарч байна.



Цаашид сайжруулах зүйлс :

Ажилтнуудын эрүүл мэндийн мэдээлэл болон зураг БСМС-д оруулах

Санал хүсэлт:

Интернетийн хурдыг сайжруулах шаардлагатай байна.

Баянгол сумын цэцэрлэгт хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний ажлын тайлан

2018-2019 оны хичээлийн жилд Баянгол сумын цэцэрлэг нь 10 бүлгийн 351 хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж нийт 30 удирдах ажилтан, багш, бусад ажилтан ажиллаж байна.

2018 оны 12 дугаар сарын 05–ны өдөр тус цэцэрлэгийн эрхлэгч Ц.Орхонцэцэг, арга зүйч А.Наранцэцэг нартай хамтран ажиллалаа.



Статистик мэдээ цаасаар хэвлэж гаргасан аймгийн нэгтгэлтэй тулгаж үзэхэд ямар нэгэн зөрүүтэй тоо илрээгүй. Багшийн журнал хөтлөлт болон хүүхдийн ирцийн мэдээлэл шалгаж үзэхэд нийт ирэх ёстой 309 хүүхдээс 2018 оны 12 сарын 05-ны өдрийн байдлаар тасалсан 17, өвчтэй 28, чөлөөтэй 13, 251 хүүхэд ирсэн байна. Үүнээс үзэхэд хүйтний эрч чангарсантай холбоотой ханиад томуу их учир хүүхэд цөөн ирж байна.

Ажиллагчдын хувийн хэргийн хавтас нэгэн жигд, материал бүрдүүлэлт хангалттай сайн байна. Харин албан бичиг хэргийн хөтлөлт (ирсэн, явсан) бичгийн бүртгэлийн карт хөтлөх, мэдээ мэдээллийн тархаалт хийх шаардлагатай байна.

Боловсролын салбарын мэдээллийн системийн бүртгэлийн хүрээнд:

Хүүхдийн холбоо барих утас, гэрийн хаяг, амьдрах орчин оруулсан байна. Харин суралцагчдын зураг, эрүүл мэндийн үзлэгийн мэдээлэл оруулаагүй байна. Ажилтны хүрээнд боловсрол, холбоо барих утас, гэр бүлийн мэдээлэл, багшийн мэргэжлийн бэлтгэл, багшлах эрх зөвшөөрөл, шагнал шийтгэлийн мэдээллийг оруулсан боловч зураг, и-мэйл хаяг, баримт бичиг оруулаагүй байна. Байгууллагын хүрээнд цэцэрлэгийн байр болон өрөө анги танхим бүрэн оруулсан байна.

Цаашид сайжруулах зүйлс :

- Статистик мэдээний тархаалт хийх
- Хүүхдийн эрүүл мэндийн үзлэгийн мэдээлэл оруулах
- Ажиллагчдын зураг, и-мэйл, баримт бичиг, эрүүл мэндийн үзлэгт орсон байдалыг БСМС-д оруулах


Санал хүсэлт:

- Шилжилт хөдөлгөөн хийсэн суралцагчийг өөр аймаг, хотын цэцэрлэг хасалт түргэн шийдвэрлэж байх
- Компьютер болон интернэт орчин бүрдүүлж өгөх

Мандал сумын Нархан цэцэрлэгт хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний ажлын тайлан

2018-2019 оны хичээлийн жилд Мандал сумын нархан цэцэрлэг нь 13 бүлгийн 478 суралцагчтай 2 ээлжээр хичээллэж нийт 48 удирдах ажилтан, багш, бусад ажилтан ажиллаж байна. 2018 оны 12 дугаар сарын 06 –ны өдөр Цэцэрлэгийн эрхлэгч Г.Гэрэлмаа, арга зүйч Б.Наранцацрал нартай хамтран ажилласан.

Уг цэцэрлэгийн статистик мэдээ цаасаар хэвлэж гаргасан аймгийн нэгтгэлтэй тулгаж үзэхэд ямар нэгэн зөрүүтэй тоо илрээгүй. Багшийн журнал хөтлөлт сайн эмх цэгцтэй, балласан зүйл байхгүй байгаа нь сайшаалтай байна.



Боловсролын салбарын мэдээллийн системийн бүртгэлийн хүрээнд:

Хүүхдийн зураг, холбоо барих утас, гэрийн хаяг, өрхийн мэдээлэл, амьдрах орчин, баримт бичиг оруулсан боловч эрүүл мэндийг нь оруулаагүй орхигдуулсан байна. Ажилтны хүрээнд анхан шатны бүртгэлийн ихэнд мэдээллийг оруулсан боловч эрүүл мэнд, баримт бичиг оруулаагүй орхигдуулсан байна. Байгууллагын хүрээнд цэцэрлэгийн байр болон өрөө анги танхим оруулсан. цэцэрлэгийн нэршил буюу тусгай зөвшөөрөл дээрх нэр мэдээллийн системийн нэртэй таарч байна.

Цаашид сайжруулах зүйлс :

- Ажилтнуудын эрүүл мэнд, зураг, баримт бичиг БСМС-д оруулах
- Мэдээний тархаалт хийх

Санал хүсэлт:

- Интернетийн хурдыг сайжруулах шаардлагатай байна.

Мандал сумын 1-р цэцэрлэгт хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний ажлын тайлан

2018-2019 оны хичээлийн жилд Мандал сумын 1-р цэцэрлэг нь 7 бүлгийн 293 хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж нийт 31 удирдах ажилтан, багш, бусад ажилтан ажиллаж байна. 2018 оны 12 дугаар сарын 06-ны өдөр тус цэцэрлэгийн эрхлэгч Л.Бүрэнжаргал, арга зүйч Д.Энхчимэг нартай хамтран ажиллалаа.

Статистик мэдээ цаасаар хэвлэж гаргасан аймгийн нэгтгэлтэй тулгаж үзэхэд ямар нэгэн зөрүүтэй тоо илрээгүй. Ажиллагчдын хувийн хэргийн хавтас нэгэн жигд, материал бүрдүүлэлт хангалттай сайн байна. Харин албан бичиг хэргийн хөтлөлт (ирсэн, явсан) бичгийн бүртгэлийн карт хөтлөх, мэдээ мэдээллийн тархаалт хийх шаардлагатай байна.

Боловсролын салбарын мэдээллийн системийн бүртгэлийн хүрээнд:

Хүүхдийн холбоо барих утас, гэрийн хаяг, амьдрах орчин, зураг, эрүүл мэндийн үзлэгийн мэдээлэл бүрэн оруулсан байна. Ажилтны хүрээнд боловсрол, холбоо барих утас, гэр бүлийн мэдээлэл, багшийн мэргэжлийн бэлтгэл, багшлах эрх зөвшөөрөл, шагнал шийтгэлийн мэдээллийг оруулсан боловч зураг, баримт бичиг оруулаагүй байна. Байгууллагын хүрээнд цэцэрлэгийн байр болон өрөө анги танхим бүрэн оруулсан байна.

Цаашид сайжруулах зүйлс :

- Статистик мэдээний тархаалт хийх
- Ажилтны эрүүл мэндийн үзлэгийн мэдээлэл оруулах

Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуульд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний ажлын тайлан

2018-2019 оны хичээлийн жилд Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль нь 33 бүлгийн 897 хүүхэд ЕБС-д хамрагдаж нийт 77 удирдах ажилтан, багш, бусад ажилтан ажиллаж байна. 2018 оны 12 дугаар сарын 06-ны өдөр тус сургуулийндунд ангийн сургалтын менежер А.Цэнд-аюуш нартай хамтран ажиллалаа.

Статистик мэдээ цаасаар хэвлэж гаргасан боловч баталгаажуулж тамга тэмдэг даруулаагүй байна. Мөн мэдээний тархаалт хийх шаардлагатай байна.



Боловсролын салбарын мэдээллийн системийн бүртгэлийн хүрээнд:

Хүүхдийн холбоо барих утас, гэрийн хаяг, амьдрах орчин, зураг, эрүүл мэнд, дүрэмт хувцас оруулсан боловч баримт бичиг оруулаагүй байна. Ажилтны хүрээнд боловсрол, холбоо барих утас, гэр бүлийн мэдээлэл, багшийн мэргэжлийн бэлтгэл, багшлах эрх зөвшөөрөл, шагнал шийтгэлийн мэдээллийг оруулсан боловч зураг, эрүүл мэнд оруулаагүй байна. Байгууллагын хүрээнд сургуулийн байр болон өрөө анги танхим бүрэн оруулсан байна.

Цаашид сайжруулах зүйлс :

- Статистик мэдээний тархаалт хийх
- Ажилтны эрүүл мэндийн үзлэгийн мэдээлэл оруулах
- Суралцагчын баримт бичиг оруулах
- Багш журнал хөтлөлт сайжруулах

Мандал сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуульд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний ажлын тайлан

2018-2019 оны хичээлийн жилд Мандал сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургууль нь 41 бүлгийн 1298 хүүхэд ЕБС-д хамрагдаж нийт 83 удирдах ажилтан, багш, бусад ажилтан ажиллаж байна.

2018 оны 12 дугаар сарын 06-ны өдөр тус сургуулийн дунд ангийн сургалтын менежер Ж.Мягмарсүрэнтэй хамтран ажиллалаа. Статистик мэдээг аймгийн нэгтгэлтэй тулгаж үзэхэд ямар нэгэн зөрүүтэй тоо илрээгүй.

Боловсролын салбарын мэдээллийн системийн бүртгэлийн хүрээнд:

Хүүхдийн холбоо барих утас, гэрийн хаяг, амьдрах орчин, зураг, эрүүл мэнд, дүрэмт хувцас оруулсан боловч баримт бичиг оруулаагүй байна. Ажилтны хүрээнд боловсрол, холбоо барих утас, гэр бүлийн мэдээлэл, багшийн мэргэжлийн бэлтгэл, багшлах эрх зөвшөөрөл, шагнал шийтгэлийн мэдээллийг

оруулсан байна. Байгууллагын хүрээнд сургуулийн байр болон өрөө анги танхим бүрэн оруулсан байна. Анхан шатны бүртгэлийг бүрэн хийсэн нь сайн байна.

Цаашид сайжруулах зүйлс :

- Статистик мэдээний тархаалт сайжруулах
- Сурагчийн эрүүл мэндийн мэдээлэл оруулах
- Статистик мэдээ цаасаар гарсан бол баталгаажуулалт хийх

Мандал сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуульд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний ажлын тайлан

2018-2019 оны хичээлийн жилд Мандал сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 37 бүлгийн 964 хүүхэд ЕБС-д хамрагдаж нийт 103 удирдах ажилтан, багш, бусад ажилтан ажиллаж байна. 2018 оны 12 дугаар сарын 06–ны өдөр тус сургуулийн дунд ангийн сургалтын менежер Т.Амарсайхантай хамтран ажиллалаа. Статистик мэдээг аймгийн нэгтгэлтэй тулгаж үзэхэд ямар нэгэн зөрүүтэй тоо илрээгүй.



Боловсролын салбарын мэдээллийн системийн бүртгэлийн хүрээнд:

Хүүхдийн холбоо барих утас, амьдрах орчин, зураг, эрүүл мэнд, баримт бичиг, дүрэмт хувцас оруулсан боловч гэрийн хаяг оруулаагүй байна.

Ажилтны хүрээнд боловсрол, холбоо барих утас, гэр бүлийн мэдээлэл, багшийн мэргэжлийн бэлтгэл, багшлах эрх зөвшөөрөл, шагнал шийтгэлийн мэдээллийг оруулсан байна.

Байгууллагын хүрээнд сургуулийн байр болон өрөө анги танхим бүрэн оруулсан байна.

Анхан шатны бүртгэлийг бүрэн хийсэн нь сайн байна.

Цаашид сайжруулах зүйлс :

- Сурагчийн эрүүл мэндийн мэдээлэл бүрэн оруулах

**Эрүүл мэндийн төвийн шинжилгээ үнэлгээний
ажлын тайлан**

Эрүүл мэндийн төвүүдэд анхан шатны маягт дутуу хөтлөгддөг, эмчийн үзлэгийн бүртгэл хөтлөлт дутуу, их,бага эмч нарын үзлэгийн бүртгэл хөтлөлт ханаглтгүй, өвчтөний түүх бичилт дутуу, нас баралтын гэрчилгээний бичилт дутуу үхэлд хүргэсэн шууд шалтгаан, үхлийн үндсэн шалтгаан, үхлийн үндсэн шалтгааныг тодорхой бичээгүй, оношийн кодыг 4 оронгийн түвшинд ашиглаагүй зэрэг нийтлэг алдаа дутагдал гарсан сумдын Эрүүл мэндийн төвүүдэд зөвлөгөө өгч гаргасан алдаа дутагдлыг засч залруулан эргэн мэдээлэх үүрэг өглөө.

Алтанбулаг сумын Эрүүл мэндийн төв



Баянгол сумын Эрүүл мэндийн төв

Мандал сумын Эрүүл мэндийн төв



Баруунбүрэн сумын Эрүүл мэндийн төв



2018 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ТАЙЛАН

Хагас жилийн малын түүвэр судалгааны хяналт шалгалт / 2018 он 6 сар /

Хяналтад хамруулсан сум:	Хяналтад хамруулсан багууд:	Хяналтын тооллого хийсэн өрхийн тоо	Судалгаанд хамрагдах өрх	Тооллогын явцад тохиолдсон хүндрэл бэрхшээл, түүнийг шийдвэрлэсэн арга зам, гарсан зөрчил	Бусад
Зүүнбүрэн, Орхон, Сант, Сайхан Сүхбаатар сум	Зүүнбүрэн сум Жаргалант 1-р Зүүнбүрэн сум Бэлчир 2-р баг Орхон сумын Бэлэндалай 2-р баг Сант сумын Хушаат 2-р баг Сайхан сумын Номгон 3-р баг Сайхан сумын Гавшгай 2-р баг Сүхбаатар сумын Бор гүвээ 5-р баг	50	Судалгаанд хамрагдах ёстой 1552 өрхөөс судалгаанд бүгд хамрагджээ.	1.Малчид зусландаа гарсан, нийт нутгаар гантай байгаа тул оторт явсан байгаа учир шатахуун хүрэлцээ муу байна. 2. Цаг агаар хэт халуун байсан.	ХАА-н газрын дарга Б.Мөнхтөр, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн дарга С.Отгонжаргал Татварын хэлтсийн дарга Х.Батболд нар Зүүнбүрэн, Сүхбаатар сумдад 2018.06.11-2018.06.13 хооронд хяналтын тооллого хийлээ, мөн Орхон, Сант, Сайхан суманд Статистикийн хэлтсийн дарга Д.Гүндэгмаа, Статистикийн хэлтсийн мэргэжилтэн Х.Батбаатар нар ажиллаж, Хагас жилийн мал тооллогын

Нийт 5 сум	Нийт 7 баг	Нийт 50 өрх	Нийт хүндрэл, бэрхшээл, зөрчил: 2	судалгааны явцад мониторинг хийлээ. /2018.06.11-13ны өдрүүдэд/
------------	------------	-------------	-----------------------------------	--

Жилийн эцсийн малын хяналтын тооллогын хяналт шалгалт / 2018 он 12 сар /

Хяналтад хамруулсан сум:	Хяналтад хамруулсан багууд:	Хяналтын тооллого хийсэн өрхийн тоо	Тооллогын явцад тохиолдсон хүндрэл бэрхшээл, түүнийг шийдвэрлэсэн арга зам гарсан зөрчил	Бусад
Шаамар, Сант, Баруунбүрэн, Хушаат, Мандал, Баянгол сум	Шаамар сум Охиндий 2-р баг Сант сум Ивэн 2-р баг Баруунбүрэн сум Ивэн 1-р баг Хушаат сум Мөнхтолгой 2-р баг Мандал сум Баянсуудал 3-р баг, Мандал сум Төмөрзамчин 1-р баг, Мандал сум Минжийн хангай 7-р баг Баянгол сум Хараа 1-р баг	30	<p>1. Сант сумын хяналтын тооллогын явцад дараах зөрчил илэрч, илэрсэн зөрчлийг ажлын хэсэгт танилцуулж залруулсан болно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Малчин өрхийн ахуйн зарим үзүүлэлтийг нөхөөгүй - Малын хашаа хэсгийн мэдээллийг дутуу бөгөлсөн. <p>2. Хушаат сумын хяналтын тооллогын явцад дараах зөрчил илэрч, илэрсэн</p>	Аймгийн Засаг даргын 2018 оны А/424 дугаар захирамжийн дагуу аймгийн мал тооллогын ажлын хэсэг ХААГазрын дарга Б.Мөнхтөр, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга М.Нарантуяа, Статистикийн хэлтсийн дарга Д.Гүндэгмаа,

	Баянгол сум Баян 2-р баг Баянго сум Гонир 3-р баг		<p>зөрчлийг ажлын хэсэгт танилцуулж залруулсан болно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - ААНБ-ын малыг тоолсон цоохор хуудас өгөөгүй. - Малчдын мэдээлэл хэсгийг дутуу нөхсөн. - Малчин өрхийн ахуйн зарим үзүүлэлтийг нөхөөгүй - Мал тооллогын маягтын худаг, усан сан, малын хашаа хэсгийн мэдээллийг буруу нөхсөн. <p>3. Шаамар суманд хяналтын тооллогын явцад дараах зөрчил илэрч, илэрсэн зөрчлийг ажлын хэсэгт танилцуулж залруулсан болно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Мал тооллогын маягтын худаг, усан сан, малын хашаа хэсгийн мэдээллийг буруу нөхсөн. 	<p>мэргэжилтэн Х.Батбаатар, Хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалт, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн н.Бүрэнжаргал, Татварын хэлтсийн улсын ахлах байцагч Д.Тайван, ХААГазрын МАА-н хэлтсийн мэргэжилтэн М.Баасанжаргал, ҮСХ-ноос хяналтын тооллогын ажлын хэсэг Эдийн засгийн статистикийн газрын шинжээч Б.Уянга, н.Энхбаатар нар хамтран 2018 оны 12 дугаар сарын 10-14-ны өдрүүдэд хяналт шалгалтыг хийлээ.</p>
Нийт 6 сум	Нийт 10 баг	Нийт 30 өрх	Нийт хүндрэл, бэрхшээл, зөрчил: 9	

Статистикийн анхан шатны мэдээ тайлан гаргалт, үнэн бодит байдал, сар улирлын мэдээний архивлалт, хадгалалт дээр шалгалт хийж, заавар зөвлөгөө өгч ажиллалаа. /2018 оны 6, 8, 9 сар/:

Хяналтад хамруулсан сум:	Хамрагдсан хүрээ	Хийсэн ажил
<p>Сүхбаатар, Алтанбулаг, Мандал, Баянгол, Сайхан, Түшиг, Зүүнбүрэн, Цагааннуур, Орхон, Сант сум</p>	<p style="text-align: center;">Сүхбаатар сум</p> <ul style="list-style-type: none"> • Сүхбаатар сум Хонгорморьт 1-р баг • Сүхбаатар сум Цагаан эрэг 2-р баг • Сүхбаатар сум Салхит 3-р баг • Сүхбаатар сум Баянхан 4-р баг • Сүхбаатар сум Боргүвээ 5-р баг • Сүхбаатар сум Орхон 6-р баг • Сүхбаатар сум Ганзам 7-р баг • Сүхбаатар сум Буурхээр 8-р баг <p>Мандал сум</p> <ul style="list-style-type: none"> • Статистик мэдээ хариуцсан мэргэжилтэн • Мандал сум Ширхэнцэг 2-р баг • Мандал сум Баянсуудал 3-р баг • Мандал сум Минийнхангай 7-р баг • Мандал сум Бүргэдэй 9-р баг 	<ul style="list-style-type: none"> ➤ 2017-2018 оны Үнийн статистик мэдээний архивлалт, мэдээ баталгаажуулсан гарын үсэг, тамга тэмдгийн бүрэн байдал. ➤ Үнийн статистик мэдээллийн хамралт, чанарыг сайжруулах, мэдээллийн бодит байдлыг хангах, асуудлаар сумдын статистик хариуцсан ажилтан нарт зөвлөмж зөвлөгөө өглөө. ➤ Сар бүрийн 15-наас 20-ны хооронд сонгогдсон аж ахуйн нэгж, байгууллагуудаас 238 нэр төрлийн бараа үйлчилгээний үнийн мэдээг мэдээ хариуцсан ажилтан өөрийн биеэр очиж авсан байна. ➤ Статистик мэдээллийн тархаалт, хэрэглэгчдэд зориулсан сургалт, Статистикийн тухай хуулийг хэрэгжүүлж байгаа үйл явц, төрийн албан хаагчийн ёс зүй, ажил үүргийн уялдаа холбоо. ➤ Анхдагч мэдээлэл өгч буй ААНБ, дэлгүүр хошооллын мэдээг бүрэн хамруулах заагдсан хугацаанд бүрэн дамжуулах. ➤ Үнийн статистик мэдээг хэрхэн цахим болон

	<p style="text-align: center;">Баянгол сум</p> <ul style="list-style-type: none"> • Хөдөө аж ахуйн тасаг • Баянгол сумын Хараа 1-р баг • Баянгол сумын Баян 2-р баг • Баянгол сумын Буурагчин 3-р баг • Статистик мэдээ хариуцсан ажилтан <p style="text-align: center;">Сайхан сум</p> <ul style="list-style-type: none"> • Статистик мэдээ хариуцсан ажилтан • Сайхан сум Хөтөл 1-р баг • Сайхан сум Гавшгай 2-р баг • Сайхан сум Номгон 3-р баг <p style="text-align: center;">Алтанбулаг сум</p> <ul style="list-style-type: none"> • Статистик мэдээ хариуцсан ажилтан • Алтанбулаг сумын Бүргэдэй 1-р баг • Алтанбулаг сум Суварга 2-р баг • Алтанбулаг сум Цөх 3-р баг <p style="text-align: center;">Түшиг сум</p> <ul style="list-style-type: none"> • Түшиг сум Жаргалмандах 1-р баг • Түшиг сум Арнуга 2-р баг <p style="text-align: center;">Зүүнбүрэн сум</p>	<p>цаасан хэлбэрээр хугацаанд нь илгээх, хойшид мэдээний чанарыг сайжруулж анхаарч ажиллах асуудал</p> <ul style="list-style-type: none"> ➤ Баянгол, Сайхан, Алтанбулаг, Мандал, Сүхбаатар суманд тухайн хугацаанд хийсэн хяналт шалгалтын дүнд: Үнийн статистикийн мэдээ хариуцсан мэргэжилтэн нь Статистик мэдээ, мэдээлэл тархаалт хийдэг самбартай тухай бүрт нь шинэчлэлт баяжилт хийж ажиллаж байсан. Үнийн статистик мэдээ мэдээлэл үнэн бодит байх нь анхдагч мэдээлэл өгч буй бүхийл төрлийн нэгжүүдээс шууд хамааралтай байдаг ийм учир өгч буй мэдээ мэдээлэлд ач холбогдол өгч үнэн бодит мэдээ мэдээлэл өгч байх, яаж өгөх, ямар хугацаанд өгөх, үнийн мэдээний чанарыг сайжруулах тал дээр заавар зөвлөгөө өгч ажиллаа. ➤ ХАӨМС-нд шинээр үзүүлэлт нэмэгдэж орсонтой холбоотойгоор үүссэн 109 мянга гаруй алдаа, дутуу өгөгдөлийг 9 дүгээр сарын 20-ны дотор засаж дуусгасан. 12 сарын 6-ны байдлаар дахин 853 алдаа, дутуу өгөгдөл гарсан байна. Цаашид гарсан алдаа, дутуу өгөгдөлийг засварлах арга хэмжээг тогтмол хийж ажиллана. ➤ Жавхлант, Баянгол, Шаамар, Орхон сумдын 7 багын компьютер дээр ХАӨМС-ын программыг суулган өглөө.
--	--	--

	<ul style="list-style-type: none"> • Зүүүнбүрэн сум Жаргалант 1-р баг • Зүүүнбүрэн сум Бэлчир 2-р баг • Зүүүнбүрэн сум Мангирт 3-р баг <p style="text-align: center;">Цагааннуур сум</p> <ul style="list-style-type: none"> • Цагааннуур сум Оргих 1-р баг • Цагааннуур сум Хуурч 2-р баг • Цагааннуур сум Тийрэг 3-р баг <p style="text-align: center;">Орхон сум</p> <ul style="list-style-type: none"> • Орхон сум Орхон 1-р баг • Орхон сум Бэлэндалай 1-р баг <p style="text-align: center;">Сант сум</p> <ul style="list-style-type: none"> • Сант сум Ивэн 1-р баг • Сант сум Хушаат 2-р баг 	<ul style="list-style-type: none"> ➤ Статистик мэдээг харахад мэдээний хавтасгүй, 2017 оны хөдөө аж ахуйн мэдээг үдээгүй, аж ахуйн нэгж, байгууллагаас авсан мэдээний зарим нь тамга, гарын үсгээр баталгуулаагүй ➤ Статистик мэдээний архивлалтын хаягжуулалтыг бичээгүй, 2015, 2016, 2017 оны хамтад үдсэн байна. Мэдээ тус бүрээр, он оноор нь салгаж үдээгүй байв. ➤ Мэдээний үндсэн маягт буюу нэг хувийг нь сумандаа авч үлдээгүй аймгийн статистикийн хэлтэст явуулсан байна. 1-р багийн Засаг дарга 2017 оны малын “ А “ дансыг үдэж цэгцлээгүй байна. ➤ Статистик мэдээллийн тархаалт дээр статистикийн самбар байршуулан эдийн засгийн ерөнхий үзүүлэлт байршуулсан байна. ➤ Мандал суманд ажиллах хугацаанд Статистикч, эдийн засагч Эрдэнэбаяр нь Статистик мэдээлэл, түүний тархаал бусдад мэдээлэл өгдөг ба Статистик мэдээллийн самбартай түүнийгээ шинэчилж, эдийн засгийн ерөнхий үзүүлэлт, хүн ам зүйн мэдээлэл, сарын танилцуулга, инфог байршуулсан байна мэдээ мэдээллээ оруулдаг байсан нь сайшаалтай сайн ажиллаж байв. ➤ Мөн 2017 он, 2018 оны Статистик мэдээний архивлалтын хаягжуулалт, мэдээ баталгаажуулсан гарын үсэг, тамга тэмдгийн бүрэн байдал сайн
--	--	---

		<p>байв.</p> <ul style="list-style-type: none"> ➤ Статистик мэдээний батлагдсан маягтан дээр хэрхэн ажиллах хэрхэн бөглөх, мэдээ мэдээлэл дамжуулах хугацаанд цахим хэлбэрээр болон маягтаар илгээх тал дээр заавар зөвлөмж өгч ажилласан. <p>Алтанбулаг, Баянгол, Мандал суманд ажиллахад :</p> <ul style="list-style-type: none"> ➤ Сурталчилгаа, мэдээлэл тархаалтын хувьд статистикийн тухай хууль, дүрэм журмыг мэдээллийн самбар дээр байршуулсан боловч мэдээллээ шинэчлээгүй байсан. 6. Статистик мэдээ, тайланг графикт хугацаанд аж ахуй нэгж, байгууллагуудаас цуглуулан авч байгаа боловч доторхи мэдээний алдаа дутагдлыг хянан шалгалгүй шууд статистикийн хэлтэст дамжуулж байна. 7. Багийн засаг дарга нартай хамтран ажиллаж өрх, хүн амын мэдээллийн сан, хөдөө аж ахуйн мэдээллийн программуудыг шалган баяжилт хийх алдааг бууруулах шаардлагатай байна. 8. Архивын тухай хууль, стандартыг дагаж мөрдөх шаардлагатай байна. Үүнд: Архивласан материалыг үзэхэд ноорог цаасан дээр хэвлэсэн, хаягжилт дутуу, хуудасны тоо дугаарлаагүй, түр болон байнга хадгалах нэгж үүсгээгүй, архивласан материал нь төрөлжүүлээгүй бүх салбарын бичиг
--	--	---

		<p>баримттай холилдсон.</p> <p>Иймд дээрх илэрсэн алдаа дутагдал бүрийг засч залруулах тал дээр заавар зөвлөмж өгч сумын Засаг орлогч дарга, тамгын газрын дарга нарт танилцуулан ажиллалаа.</p>
Нийт 10 сум	Нийт 30 баг	Нийт хүндрэл, бэрхшээл, зөрчил: 8

Аж ахуйн нэгж, байгууллагад хийсэн хяналт шалгалт: Статистикийн анхан шатны мэдээ тайлан гаргалт, үнэн бодит байдал, сар улирлын мэдээний архивлалт, хадгалалт дээр шалгалт хийж, заавар зөвлөгөө өгч ажиллалаа. /2018 оны 8, 12 сар/:

Хяналтад хамруулсан сум:	Хамрагдсан хүрээ	Хийсэн ажил
---------------------------------	-------------------------	--------------------

<p>Сүхбаатар, Мандал, Баянго сум</p>	<p style="text-align: center;">Сүхбаатар сум</p> <ul style="list-style-type: none"> • Цахим Ертөнц ХХК • Гурван мэргэд ХХК • Сэлэнгэ менежмент ХХК • Олон улсын худалдааны төв • Таванхан Уул ХХК • Залуу сэлэнгэ ХХК • Өгөөж бэлэг сэлэнгэ ХХК <p style="text-align: center;">Мандал сум</p> <ul style="list-style-type: none"> • Сая сарнай ЗБН • Томон ХХК • Оюу болд ЗБН <p>Баянгол сум</p> <ul style="list-style-type: none"> • Хатан сондор ХХК • Ган зам ХХК • Ууган эрхэс ХХК 	<ul style="list-style-type: none"> ➤ Үнийн статистик мэдээний хамралт, чанарыг сайжруулах, бодит байдлыг хангах, асуудлаар аж ахуйн нэгж, байгууллагуудад зөвлөмж зөвлөгөө өглөө. ➤ Сар бүрийн 15-наас 20-ны хооронд сонгогдсон аж ахуйн нэгж, байгууллагуудаас 238 нэр төрлийн бараа үйлчилгээний үнийн мэдээг мэдээ хариуцан ажилтан өөрийн биеэр очиж авсан байна. ➤ Үнийн индексийн тооцоонд ашиглах суурь үнэ цуглуулах судалгаанд Сүхбаатар сумын Цахим Ертөнц ХХК, Сэлэнгэ менежмент ХХК, Гурван мэргэд ХХК, Олон улсын худалдааны төв хамрагдсан. Уг үнийн судалгааг сарын эцэст тооллогын бүртгэлээр үнийг гарган өгч 14 хоногт 1 удаа тооллого хийж судалгаагаа гаргадаг байна. Эдгээр аж ахуйн нэгж, байгууллагууд тогтмол мэдээгээ өгч хэвшсэн байна. ➤ 2017 он, 2018 оны хагас жилийн байдлаарх Статистик мэдээний архивлалтын хаягжуулалтыг бичээгүй, мэдээ баталгаажуулсан гарын үсэг, тамга тэмдгийн бүрэн байдал дутуу байв. ➤ Статистик мэдээллийн тархаалт дээр статистикийн самбар байршуулан эдийн засгийн ерөнхий үзүүлэлт, хүн ам зүйн мэдээлэл, мөн хөлтэй
--	---	---

		<p>самбар дээр статистик мэдээний маягтууд, сарын танилцуулга, инфо, улсын эмхэтгэлийг байршуулсан байна.</p> <ul style="list-style-type: none"> ➤ Статистикийн тухай хуулийг хэрэгжүүлж байгаа үйл явц, төрийн албан хаагчийн ёс зүй, ажил үүргийн уялдаа холбоог үзэж шалгалаа. ➤ Статистик мэдээний батлагдсан маягтан дээр хэрхэн ажиллах хэрхэн бөглөх, мэдээ мэдээлэл дамжуулах хугацаанд цахим хэлбэрээр болон маягтаар илгээх тал дээр заавар зөвлөмж өгч ажилласан. ➤ ХАА-н тасгийн мэдээ архивлалт сайн байлаа. 2017 оны А дансыг үдэж цэгцэлсэн байв. ➤ ХАӨМСангийн баяжилтийг 4-р багийн Засаг дарга Отгонзаяа 3000 гаруй алдааг засч дуугасан байна. ХАӨМСан дээр эдийн засагч Ганбаярыг багуудтай хамтран ажиллах талаар чиглэл өглөө. ➤ Таванхан Уул ХХК, Залуу сэлэнгэ ХХК, Өгөөж бэлэг сэлэнгэ ХХК нь мэдээгээ улирал бүр Сүхбаатар суманд өгч хэвшсэн байна. Мэдээ баталгаажуулалт харьцангуй сайн байлаа. <p>Засаг даргын 05 тоот албан даалгавар болон Статистикийн хэлтсийн дотоод хяналт шалгалтын ажлын дагуу Сүхбаатар суманд ажиллахад :</p> <ul style="list-style-type: none"> ➤ Сурталчилгаа, мэдээлэл тархаалтын хувьд статистикийн тухай хууль, дүрэм журмыг
--	--	---

		<p>мэдээллийн самбар дээр байршуулсан боловч мэдээллээ шинэчлээгүй, 2014 оны мэдээлэл байсан. Мэдээллийн самбарыг тогтмол баяжуулан шинэчлэл хийгээгүй.</p> <ul style="list-style-type: none"> ➤ Статистик мэдээ, тайланг графикт хугацаанд аж ахуй нэгж, байгууллагуудаас цуглуулан авч байгаа боловч доторхи мэдээний алдаа дутагдлыг хянан шалгалгүй шууд статистикийн хэлтэст дамжуулж байна. ➤ Анхдагч нэгжээс авсан мэдээ, тайланг өөрөө давхар хянаж өмнөх сар, улирал жилийн мэдээтэй уялдуулан гарсан алдаа зөрчил бүрийг тухайн газраар засуулж байхыг анхааруулж хэлсэн. ➤ Багийн засаг дарга нартай хамтран ажиллаж өрх, хүн амын мэдээллийн сан, хөдөө аж ахуйн мэдээллийн программуудыг шалган баяжилт хийх алдааг бууруулах шаардлагатай байна. ➤ Архивын тухай хууль, стандартыг дагаж мөрдөх шаардлагатай байна. Үүнд: Архивласан материалыг үзэхэд ноорог цаасан дээр хэвлэсэн, хаягжилт дутуу, хуудасны тоо дугаарлаагүй, түр болон байнга хадгалах нэгж үүсгээгүй, архивласан материал нь төрөлжүүлээгүй бүх салбарын бичиг баримттай холилдсон. <p>Иймд дээрх илэрсэн алдаа дутагдал бүрийг засч залруулах тал дээр заавар зөвлөмж өгч сумын Засаг</p>
--	--	---

		орлогч дарга, тамгын газрын дарга нарт танилцуулан ажиллалаа.
Нийт 3 сум	Нийт 13 аж ахуйн нэгж,байгууллага	Нийт хүндрэл, бэрхшээл, зөрчил: 10

Аймгийн Эрүүл мэндийн газар, Боловсрол соёл урлагийн газартай хамтран хийсэн хяналт шалгалт: Статистикийн анхан шатны мэдээ тайлан гаргалт, үнэн бодит байдал, сар улирлын мэдээний архивлалт, хадгалалт дээр шалгалт хийж, заавар зөвлөгөө өгч ажиллалаа. /2018 оны 12 сар/:

Хяналтад хамруулсан сум:	Хамрагдсан хүрээ	Хийсэн ажил
Алтанбулаг, Баянгол, Мандал, Баруунбүрэн, Сүхбаатар сум	<p>Алтанбулаг сум</p> <ul style="list-style-type: none"> • 12 жилийн дунд сургууль • Найрамдал 1-р цэцэрлэг • Эрүүл мэндийн төв <p>Сүхбаатар сум</p>	Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2018 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн А/372 тоот захирамжийн дагуу хяналт-шинжилгээ үнэлгээний ажлыг Статистикийн хэлтсийн дарга, улсын байцаагч Д.Гүндэгмаа, ахлах мэргэжилтэн, улсын байцаагч Ч.Цэнд-Аюуш, Эрүүл мэндийн газрын хяналт-шинжилгээ үнэлгээ мониторингийн хэлтсийн мэргэжилтэн Д.Буяндэлгэр,

	<ul style="list-style-type: none"> • 12 жилийн 4-р сургууль, 1-р сургууль • Улсын тэргүүний 4-р цэцэрлэг, 3-р цэцэрлэг <p style="text-align: center;">Баянгол сум</p> <ul style="list-style-type: none"> • 12 жилийн дунд сургууль • Солонго цэцэрлэг • Эрүүл мэндийн төв <p style="text-align: center;">Мандал сум</p> <ul style="list-style-type: none"> • 12 жилийн 4-р сургууль, 3-р сургууль, 1-р сургууль • Нархан цэцэрлэг, 1-р цэцэрлэг • Эрүүл мэндийн төв <p style="text-align: center;">Баруунбүрэн сум</p> <ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн төв 	<p>Боловсрол, соёл, урлагийн газрын статистик, хяналт – шинжилгээ үнэлгээний мэргэжилтэн Э.Долгормаа нар хамтран Монгол улсын “Статистикийн тухай” хуулийн хэрэгжилтийг хангах, гарч болзошгүй эрсдэл, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, анхан шатнаас цуглуулж байгаа болон тооллого, анхдагч мэдээллийн чанарт тавих нэгжийн дотоод хяналтыг сайжруулах, үр нөлөөг дээшлүүлэх, ингэснээр анхан шатны болон тооллого, судалгааны анхдагч мэдээллийн чанарыг улам сайжруулах зорилгоор Сүхбаатар, Алтанбулаг, Мандал, Баянгол, Баруунбүрэн сумын сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төв, сумын ЗДТГазар дээр ажиллалаа.</p> <p style="text-align: center;">Сүхбаатар сумын ерөнхий боловсролын лаборатори 4 дүгээр сургуульд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний ажлын тайлан</p> <p>2018-2019 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын лаборатори 4 дүгээр сургууль нь 32 бүлгийн 932 суралцагчтай 2 ээлжээр хичээллэж нийт 63 удирдах ажилтан, багш, бусад ажилтан ажиллаж байна. 2018 оны 11 дүгээр сарын 12 –ны өдөр сургуулийн дунд ангийн сургалтын менежер Д.Алтанцэцэг, бага ангийн сургалтын менежер Л.Оюунтүлхүүр нартай хамтран ажиллалаа.</p> <p>Уг сургуулийн албан бичиг хэргийн хөтлөлт эмх</p>
--	---	---

		<p>цэгцтэй, бүртгэлийн номер дугаар зөрсөн, давхардсан зүйл байхгүй, статистик мэдээ цаасаар хэвлэж гаргасан аймгийн нэгтгэлтэй тулгаж үзэхэд ямар нэгэн зөрүүтэй тоо илрээгүй. Сургуулийн мэдээ мэдээллийн самбарт энэ хичээлийн жилийн статистик мэдээнд үндэслэн иргэдэд зориулсан зарим тоон мэдээллийг тодорхой хэмжээнд нээлттэй ил тод байсан мөн багшийн журнал хөтлөлт сайн байгаа нь сайшаалтай байна.</p> <p>Боловсролын салбарын мэдээллийн системийн бүртгэлийн хүрээнд:</p> <p>Суралцагчдын холбоо барих утас, гэрийн хаяг, өрхийн мэдээлэл, дүрэмт хувцас, сурах бичиг амьдрах орчин оруулсан боловч баримт бичиг, мэдээллийн шинчлэлтийг хийгээгүй байна. Мөн бага боловсрол эзэмшиж байгаа хүүхдийн эрүүл мэндийн мэдээллийг оруулсан боловч дунд анги болон ахлах ангийн суралцагчдын эрүүл мэндийн мэдээлэл оруулаагүй байна. Ажилтны хүрээнд анхан шатны бүртгэлийн ихэнд мэдээллийг оруулсан боловч гэрийн хаяг болон эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамрагдсан байдлыг оруулаагүй орхигдуулсан байна.</p> <p>Байгууллагын хүрээнд хичээлийн байр болон өрөө анги танхим оруулсан. сургуулийн нэгшил буюутусгай зөвшөөрөл дээрх нэр мэдээллийн системийн нэртэй таарч байна.</p>
--	--	---

		<p>Цаашид сайжруулах зүйлс :</p> <p>Суралцагчдын баримт бичиг, эрүүл мэндийн мэдээллийг БСМС-д оруулах Ажилтнуудын эрүүл мэндийн мэдээлэл болон гэрийн хаягыг БСМС-д оруулах</p> <p>Санал хүсэлт:</p> <p>Статистик мэдээ гаргаж байгаа буюу сургалтын менежерүүдийн компьютерийн үзүүлэлт, интернетийн хурдыг сайжруулах шаардлагатай байна.</p> <p>Ирц, үнэлгээ, хичээлийн сэдэв, ээлжит хичээлүүдийг БСМС-д оруулдаг болсонтой холбогдуулан багш, сургалтын менежерүүдийн ажлын ачаалал маш их нэмэгдэж байна. Энэ ачааллыг багасгах тал дээр статистик хариуцсан ажилтан эсвэл хүний нөөцийн ажилтантай болох саналтай байна.</p> <p>Сургуулийн бичиг хэргийн ажилнуудад албан бичиг хэргийн хөтлөлт, стандартын сургалтанд суух хүсэлтэй байна.</p> <p>Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуульд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний ажлын тайлан</p> <p>2018-2019 оны хичээлийн жилд сүхбаатар сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 45 бүлгийн 1333 суралцагчтай 2 ээлжээр хичээллэж нийт 108</p>
--	--	--

		<p>удирдах ажилтан, багш, бусад ажилтан ажиллаж байна. Статистик мэдээнд 69 суралцагч дотуур байранд амьдарч байгаагаар өгсөн бол яг өрөөдийн байдлаар 74 хүүхэд дотуур байранд сууж байна.</p> <p>2018 оны 11 дүгээр сарын 12 –ны өдөр тус сургуулийн захирал Ц.Рэнцэнноров, сургалтын менежер Н.Дэлгэрцэцэг нартай хамтран ажиллалаа.</p> <p>Уг сургуулийн албан бичиг хэргийн хөтлөлт эмх цэгцтэй, бүртгэлийн номер дугаар зөрсөн, давхардсан зүйл байхгүй, статистик мэдээ цаасаар хэвлэж гаргасан аймгийн нэгтгэлтэй тулгаж үзэхэд ямар нэгэн зөрүүтэй тоо илрээгүй. Сургуулийн мэдээ мэдээллийн самбарт энэ хичээлийн жилийн статистик мэдээнд үндэслэн бүлгийн тоон мэдээллийг тодорхой хэмжээнд нээлттэй ил тод байлгасан байна. Үүнийг хийхдээ бүлэг дүүргэлтийг хувиар илэрхийлсэн нь илүү ойлгомжтой харагдаж байна.</p> <p>Боловсролын салбарын мэдээллийн системийн бүртгэлийн хүрээнд:</p> <p>Суралцагчдын дүрэмт хувцас, амьдрах орчин оруулсан боловч баримт бичиг, холбоо барих утас, гэрийн хаяг, эрүүл мэнд, сурах бичиг, мэдээллийн шинчлэлтийг хийгээгүй байна. Харин суралцагчдын зураг оруулсан нь сайшаалтай байна.</p> <p>Ажилтны хүрээнд анхан шатны бүртгэлийн ихэнд</p>
--	--	--

		<p>мэдээллийг оруулсан боловч гэр бүлийн мэдээлэл, гэрийн хаяг оруулаагүй байна. Сургуулийн нийт ажилтан нэгдсэн журмаар эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамрагдаагүй байна.</p> <p>Байгууллагын хүрээнд хичээлийн байр болон өрөө анги танхим оруулсан. сургуулийн нэгшил буюу тусгай зөвшөөрөл дээрх нэр мэдээллийн системийн нэртэй таарч байна.</p> <p>Цаашид сайжруулах зүйлс :</p> <ul style="list-style-type: none"> - Суралцагчдын холбоо барих утас, гэрийн хаяг, сурах бичиг, баримт бичиг, эрүүл мэндийн мэдээллийг БСМС-д оруулах - Ажилтнуудын гэр бүлийн мэдээлэл болон гэрийн хаяг, ажлын түүхийг БСМС-д оруулах <p>Санал хүсэлт:</p> <ul style="list-style-type: none"> - Статистик мэдээ гаргаж байгаа буюу сургалтын менежерүүдийн компьютерийн үзүүлэлт, интернетийн хурдыг сайжруулах шаардлагатай байна. - Ирц, үнэлгээ, хичээлийн сэдэв, ээлжит хичээлүүдийг БСМС-д оруулдаг болсонтой холбогдуулан багш, сургалтын менежерүүдийн ажлын ачаалал маш их нэмэгдэж байна. Энэ ачааллыг багасгах хүсэлтэй байна. - Нийт ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан
--	--	--

		<p>сэргийлэх үзлэг оношилгоонд хамруулах саналтай байна.</p> <p>Сүхбаатар сумын 3 дугаар цэцэрлэгт хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний ажлын тайлан</p> <p>2018-2019 оны хичээлийн жилд Сүхбаатар сумын 3 дугаар цэцэрлэг нь 16 бүлгийн 452 хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж нийт 64 удирдах ажилтан, багш, бусад ажилтан ажиллаж байна.</p> <p>2018 оны 11 дүгээр сарын 13 –ны өдөр тус цэцэрлэгийн эрхлэгч П.Амарсанаа, арга зүйч З.Гэрэлтнаран нартай хамтран ажиллалаа. Статистик мэдээ цаасаар хэвлэж гаргасан аймгийн нэгтгэлтэй тулгаж үзэхэд ямар нэгэн зөрүүтэй тоо илрээгүй. цэцэрлэгийн мэдээ мэдээллийн самбарт энэ хичээлийн жилийн статистик мэдээг тавьсан байна.</p> <p>Ажиллагчдын хувийн хэргийн хавтас нэгэн жигд, материал бүрдүүлэлт хангалттай сайн байна. Харин албан бичиг хэргийн хөтлөлт (ирсэн, явсан) бичгийн бүртгэл эмх цэгц муутай, бүртгэлийн карт хөтлөлт байхгүй байна.</p> <p>Боловсролын салбарын мэдээллийн системийн бүртгэлийн хүрээнд: Хүүхдийн холбоо барих утас, гэрийн хаяг, амьдрах орчин оруулсан байна. Харин суралцагчдын зураг</p>
--	--	---

		<p>оруулаагүй байна. Ажилтны хүрээнд анхан шатны бүртгэлийн ихэнд мэдээллийг оруулсан боловч зураг оруулаагүй байна. Байгууллагын хүрээнд цэцэрлэгийн байр болон ерөө анги танхим оруулсан байна. БСМС-ийн бүртгэл хөтлөлт маш сайн хийгдсэн нь сайшаалтай байна.</p> <p>Цаашид сайжруулах зүйлс :</p> <ul style="list-style-type: none"> - БСМС-д бүртгэлтэй бүх хүний зураг оруулах - Ирсэн, явсан бичгийн бүртгэл сайн хөтлөж бүртгэлийн карт хөтлөх шаардлагатай - БСМС-д ирцийн бүртгэл үнэн зөв оруулах өөрөөр хэлбэл багшийн хөтлөж буй цаасан журналын ирц бүртгэл БСМС-ийн ирц бүртгэлтэй таарах ёстой. <p>Санал хүсэлт:</p> <ul style="list-style-type: none"> - Шилжилт хөдөлгөөн хийсэн суралцагчийг өөр аймаг, хотын цэцэрлэг хасалт түргэн шийдвэрлэж байх - Хүүхэдтэй ажиллах цаг зав хомс бөгөөд олон програм дээр ижил төрлийн мэдээлэл шивж байгааг болиулах - Компьютер болон интэрнет орчин бүрдүүлж өгөх <p>Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэгт хийсэн</p>
--	--	---

		<p style="text-align: center;">хяналт шинжилгээ үнэлгээний ажлын тайлан</p> <p>2018-2019 оны хичээлийн жилд Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэг нь 9 бүлгийн 271 хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж нийт 33 удирдах ажилтан, багш, бусад ажилтан ажиллаж байна. 2018 оны 11 дүгээр сарын 13 –ны өдөр тус цэцэрлэгийн эрхлэгч Д.Баяржаргал, арга зүйч Г.Отгонгэрэл нартай хамтран ажиллалаа. Статистик мэдээ цаасаар хэвлэж гаргасан аймгийн нэгтгэлтэй тулгаж үзэхэд ямар нэгэн зөрүүтэй тоо илрээгүй. цэцэрлэгийн мэдээ мэдээллийн самбарт энэ хичээлийн жилийн статистик мэдээг тавьсан байна. Албан бичиг хэргийн хөтлөлт (ирсэн, явсан) бичгийн бүртгэл хөтлөлт сайн байна.</p> <p>Боловсролын салбарын мэдээллийн системийн бүртгэлийн хүрээнд:</p> <p>Хүүхдийн холбоо барих утас, гэрийн хаяг, амьдрах орчин оруулсан байна. Харин суралцагчдын зураг оруулаагүй байна.</p> <p>Ажилтны хүрээнд анхан шатны бүртгэлийн ихэнд мэдээллийг оруулсан боловч зураг, баримт бичиг оруулаагүй байна.</p> <p>Байгууллагын хүрээнд цэцэрлэгийн байр болон өрөө анги танхим оруулсан байна.</p> <p>БСМС-ийн бүртгэл хөтлөлт маш сайн хийгдсэн нь сайшаалтай байна.</p>
--	--	---

		<p>Цаашид сайжруулах зүйлс :</p> <ul style="list-style-type: none"> - БСМС-д бүртгэлтэй бүх хүний зураг оруулах <p>Санал хүсэлт:</p> <ul style="list-style-type: none"> - Шилжилт хөдөлгөөн хийсэн суралцагчийг өөр аймаг, хотын цэцэрлэг хасалт түргэн шийдвэрлэж байх - Хүүхэдтэй ажиллах цаг зав хомс бөгөөд олон програм дээр ижил төрлийн мэдээлэл шивж байгааг болиулах - Архив, бичиг хэргийн сургалтанд хамрагдах саналтай байна. <p>Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургуульд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний ажлын тайлан</p> <p>2018-2019 оны хичээлийн жилд Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургууль нь 28 бүлгийн 761 суралцагчтай 2 ээлжээр хичээллэж нийт 59 удирдах ажилтан, багш, бусад ажилтан ажиллаж байна. 2018 оны 12 дугаар сарын 04 –ны өдөр Сургуулийн захирал Б.Эрдэнэочир, дунд ангийн сургалтын менежер Л.Өлзийцэнгэл нартай хамтран ажиллалаа.</p> <p>Уг сургуулийн статистик мэдээ цаасаар хэвлэж гаргасан аймгийн нэгтгэлтэй тулгаж үзэхэд ямар нэгэн зөрүүтэй тоо илрээгүй. Сургуулийн мэдээ мэдээллийн</p>
--	--	---

		<p>самбарт энэ хичээлийн жилийн статистик мэдээнд үндэслэн иргэдэд зориулсан зарим тоон мэдээллийг сонирхолтой байдлаар, тодорхой хэмжээнд нээлттэй ил тод байсан мөн багшийн журнал хөтлөлт сайн байгаа нь сайшаалтай байна.</p> <p>Боловсролын салбарын мэдээллийн системийн бүртгэлийн хүрээнд: Суралцагчдын холбоо барих утас, гэрийн хаяг, өрхийн мэдээлэл, дүрэмт хувцас, сурах бичиг амьдрах орчин, баримт бичиг, эрүүл мэнд оруулсан бөгөөд бүртгэлийг бүрэн оруулсан гэж үзэж байна.</p> <p>Цаашид сайжруулах зүйлс :</p> <ul style="list-style-type: none"> - Ажилнуудын эрүүл мэндийн мэдээлэл болон баримт бичгийг БСМС-д оруулах <p>Санал хүсэлт:</p> <ul style="list-style-type: none"> - Интернетийн хурдыг сайжруулах шаардлагатай байна. <p>Алтанбулаг сумын цэцэрлэгт хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний ажлын тайлан</p> <p>2018-2019 оны хичээлийн жилд Алтанбулаг сумын найрамдал 1-р цэцэрлэг нь 8 бүлгийн 215 хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж нийт 25 удирдах ажилтан, багш, бусад ажилтан ажиллаж байна.</p>
--	--	--

		<p>2018 оны 12 дугаар сарын 04–ны өдөр тус арга зүйч К.Эрдэнэбилэгтэй хамтран ажиллалаа.</p> <p>Статистик мэдээ цаасаар хэвлэж гаргасан аймгийн нэгтгэлтэй тулгаж үзэхэд ямар нэгэн зөрүүтэй тоо илрээгүй. Ажиллагчдын хувийн хэргийн хавтас нэгэн жигд, материал бүрдүүлэлт хангалттай сайн байна. Харин албан бичиг хэргийн хөтлөлт (ирсэн, явсан) бичгийн бүртгэлийн карт хөтлөх шаардлагатай байна. Цэцэрлэгийн арга зүйч статистик мэдээний зарим үзүүлэлтээр судалгаа хийж ажилладаг нь харагдаж байна.</p> <p>Боловсролын салбарын мэдээллийн системийн бүртгэлийн хүрээнд:</p> <p>Хүүхдийн холбоо барих утас, гэрийн хаяг, амьдрах орчин оруулсан байна. Харин суралцагчдын зураг, эрүүл мэндийн үзлэгийн мэдээлэл оруулаагүй байна. Ажилтны хүрээнд анхан шатны бүртгэлийн ихэнд мэдээллийг оруулсан боловч зураг оруулаагүй байна. Байгууллагын хүрээнд цэцэрлэгийн байр болон өрөө анги танхим бүрэн оруулсан байна. БСМС-ийн бүртгэл хөтлөлт маш сайн хийгдсэн нь сайшаалтай байна.</p> <p>Цаашид сайжруулах зүйлс :</p> <ul style="list-style-type: none"> - Статистик мэдээний тархаалт хийх - Ажиллагчдын зураг оруулах шаардлагатай
--	--	---

		<p>байна.</p> <p>Санал хүсэлт:</p> <ul style="list-style-type: none"> - Шилжилт хөдөлгөөн хийсэн суралцагчийг өөр аймаг, хотын цэцэрлэг хасалт түргэн шийдвэрлэж байх - Компьютер болон интэрнет орчин бүрдүүлж өгөх <p>Баянгол сумын ерөнхий боловсролын сургуульд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний ажлын тайлан</p> <p>2018-2019 оны хичээлийн жилд Баянгол сумын ерөнхий боловсролын сургууль нь 32 бүлгийн 889 суралцагчтай 2 ээлжээр хичээллэж нийт 72 удирдах ажилтан, багш, бусад ажилтан ажиллаж байна. 2018 оны 12 дугаар сарын 05 –ны өдөр Сургуулийн захирал Д.Сарангэрэл, дунд ангийн сургалтын менежер Г.Мөнгөнчимэг нартай хамтран ажиллалаа.</p> <p>Уг сургуулийн статистик мэдээ цаасаар хэвлэж гаргасан аймгийн нэгтгэлтэй тулгаж үзэхэд ямар нэгэн зөрүүтэй тоо илрээгүй. Сургуулийн мэдээ мэдээллийн самбарт энэ хичээлийн жилийн статистик мэдээнд үндэслэн иргэдэд зориулсан зарим тоон мэдээллийг сонирхолтой байдлаар, тодорхой хэмжээнд нээлттэй ил тод байсан мөн багшийн журнал хөтлөлт сайн байгаа нь сайшаалтай байна.</p> <p>Сургуулийн сургалтын менежер статистик мэдээний</p>
--	--	---

		<p>зарим тоон үзүүлэлттэй нэлээн их ажиллаж график болон хүснэгт хийж ажиллаж байгаа нь сайшаалтай байна.</p> <p>Боловсролын салбарын мэдээллийн системийн бүртгэлийн хүрээнд:</p> <p>Суралцагчдын зураг, холбоо барих утас, гэрийн хаяг, өрхийн мэдээлэл, дүрэмт хувцас, сурах бичиг амьдрах орчин, баримт бичиг оруулсан боловч эрүүл мэндийг нь оруулаагүй орхигдуулсан байна.</p> <p>Ажилтны хүрээнд анхан шатны бүртгэлийн ихэнд мэдээллийг оруулсан боловч эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамрагдсан байдлыг оруулаагүй орхигдуулсан байна.</p> <p>Байгууллагын хүрээнд хичээлийн байр болон өрөө анги танхим оруулсан. сургуулийн нэгшил буюу тусгай зөвшөөрөл дээрх нэр мэдээллийн системийн нэртэй таарч байна.</p> <p>Цаашид сайжруулах зүйлс :</p> <ul style="list-style-type: none"> - Ажилнуудын эрүүл мэндийн мэдээлэл болон зураг БСМС-д оруулах <p>Санал хүсэлт:</p> <ul style="list-style-type: none"> - Интернетийн хурдыг сайжруулах шаардлагатай байна. <p>Баянгол сумын цэцэрлэгт хийсэн хяналт</p>
--	--	---

		<p style="text-align: center;">шинжилгээ үнэлгээний ажлын тайлан</p> <p>2018-2019 оны хичээлийн жилд Баянгол сумын цэцэрлэг нь 10 бүлгийн 351 хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж нийт 30 удирдах ажилтан, багш, бусад ажилтан ажиллаж байна.</p> <p>2018 оны 12 дугаар сарын 05–ны өдөр тус цэцэрлэгийн эрхлэгч Ц.Орхонцэцэг, арга зүйч А.Наранцэцэг нартай хамтран ажиллалаа.</p> <p>Статистик мэдээ цаасаар хэвлэж гаргасан аймгийн нэгтгэлтэй тулгаж үзэхэд ямар нэгэн зөрүүтэй тоо илрээгүй. Багшийг журнал хөтлөлт болон хүүхдийн ирцийн мэдээлэл шалгаж үзэхэд нийт ирэх ёстой 309 хүүхдээс 2018 оны 12 сарын 05-ны өдрийн байдлаар тасалсан 17, өвчтэй 28, чөлөөтэй 13, 251 хүүхэд ирсэн байна. Үүнээс үзэхэд хүйтний эрч чангарсантай холбоотой ханиад томуу их учир хүүхэд цөөн ирж байна.</p> <p>Ажиллагчдын хувийн хэргийн хавтас нэгэн жигд, материал бүрдүүлэлт хангалттай сайн байна. Харин албан бичиг хэргийн хөтлөлт (ирсэн, явсан) бичгийн бүртгэлийн карт хөтлөх, мэдээ мэдээллийн тархаалт хийх шаардлагатай байна.</p> <p>Боловсролын салбарын мэдээллийн системийн бүртгэлийн хүрээнд:</p>
--	--	--

		<p>Хүүхдийн холбоо барих утас, гэрийн хаяг, амьдрах орчин оруулсан байна. Харин суралцагчдын зураг, эрүүл мэндийн үзлэгийн мэдээлэл оруулаагүй байна.</p> <p>Ажилтны хүрээнд боловсрол, холбоо барих утас, гэр бүлийн мэдээлэл, багшийн мэргэжлийн бэлтгэл, багшлах эрх зөвшөөрөл, шагнал шийтгэлийн мэдээллийг оруулсан боловч зураг, и-мэйл хаяг, баримт бичиг оруулаагүй байна.</p> <p>Байгууллагын хүрээнд цэцэрлэгийн байр болон өрөө анги танхим бүрэн оруулсан байна.</p> <p>Цаашид сайжруулах зүйлс :</p> <ul style="list-style-type: none"> - Статистик мэдээний тархаалт хийх - Хүүхдийн эрүүл мэндийн үзлэгийн мэдээлэл оруулах - Ажиллагчдын зураг, и-мэйл, баримт бичиг, эрүүл мэндийн үзлэгт орсон байдалыг БСМС-д оруулах <p>Санал хүсэлт:</p> <ul style="list-style-type: none"> - Шилжилт хөдөлгөөн хийсэн суралцагчийг өөр аймаг, хотын цэцэрлэг хасалт түргэн шийдвэрлэж байх - Компьютер болон интэрнет орчин бүрдүүлж өгөх
--	--	--

		<p>Мандал сумын Нархан цэцэрлэгт хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний ажлын тайлан</p> <p>2018-2019 оны хичээлийн жилд Мандал сумын нархан цэцэрлэг нь 13 бүлгийн 478 суралцагчтай 2 ээлжээр хичээллэж нийт 48 удирдах ажилтан, багш, бусад ажилтан ажиллаж байна. 2018 оны 12 дугаар сарын 06 –ны өдөр Цэцэрлэгийн эрхлэгч Г.Гэрэлмаа, арга зүйч Б.Наранцацрал нартай хамтран ажилласан.</p> <p>Уг цэцэрлэгийн статистик мэдээ цаасаар хэвлэж гаргасан аймгийн нэгтгэлтэй тулгаж үзэхэд ямар нэгэн зөрүүтэй тоо илрээгүй. Багшийн журнал хөтлөлт сайн эмх цэцэгтэй, балалсан зүйл байхгүй байгаа нь сайшаалтай байна.</p> <p>Боловсролын салбарын мэдээллийн системийн бүртгэлийн хүрээнд:</p> <p>Хүүхдийн зураг, холбоо барих утас, гэрийн хаяг, өрхийн мэдээлэл, амьдрах орчин, баримт бичиг оруулсан боловч эрүүл мэндийг нь оруулаагүй орхигдуулсан байна.</p> <p>Ажилтны хүрээнд анхан шатны бүртгэлийн ихэнд мэдээллийг оруулсан боловч эрүүл мэнд, баримт бичиг оруулаагүй орхигдуулсан байна.</p> <p>Байгууллагын хүрээнд цэцэрлэгийн байр болон өрөө анги танхим оруулсан. цэцэрлэгийн нэршил буюу тусгай зөвшөөрөл дээрх нэр мэдээллийн системийн нэртэй</p>
--	--	---

		<p>таарч байна.</p> <p>Цаашид сайжруулах зүйлс :</p> <ul style="list-style-type: none"> - Ажилнуудын эрүүл мэнд, зураг, баримт бичиг БСМС-д оруулах - Мэдээний тархаалт хийх <p>Санал хүсэлт:</p> <ul style="list-style-type: none"> - Интернетийн хурдыг сайжруулах шаардлагатай байна. <p>Мандал сумын 1-р цэцэрлэгт хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний ажлын тайлан</p> <p>2018-2019 оны хичээлийн жилд Мандал сумын 1-р цэцэрлэг нь 7 бүлгийн 293 хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж нийт 31 удирдах ажилтан, багш, бусад ажилтан ажиллаж байна. 2018 оны 12 дугаар сарын 06–ны өдөр тус цэцэрлэгийн эрхлэгч Л.Бүрэнжаргал, арга зүйч Д.Энхчимэг нартай хамтран ажиллалаа.</p> <p>Статистик мэдээ цаасаар хэвлэж гаргасан аймгийн нэгтгэлтэй тулгаж үзэхэд ямар нэгэн зөрүүтэй тоо илрээгүй.</p> <p>Ажиллагчдын хувийн хэргийн хавтас нэгэн жигд, материал бүрдүүлэлт хангалттай сайн байна. Харин</p>
--	--	--

		<p>албан бичиг хэргийн хөтлөлт (ирсэн, явсан) бичгийн бүртгэлийн карт хөтлөх, мэдээ мэдээллийн тархаалт хийх шаардлагатай байна.</p> <p>Боловсролын салбарын мэдээллийн системийн бүртгэлийн хүрээнд:</p> <p>Хүүхдийн холбоо барих утас, гэрийн хаяг, амьдрах орчин, зураг, эрүүл мэндийн үзлэгийн мэдээлэл бүрэн оруулсан байна. Ажилтны хүрээнд боловсрол, холбоо барих утас, гэр бүлийн мэдээлэл, багшийн мэргэжлийн бэлтгэл, багшлах эрх зөвшөөрөл, шагнал шийтгэлийн мэдээллийг оруулсан боловч зураг, баримт бичиг оруулаагүй байна. Байгууллагын хүрээнд цэцэрлэгийн байр болон өрөө анги танхим бүрэн оруулсан байна.</p> <p>Цаашид сайжруулах зүйлс :</p> <ul style="list-style-type: none"> - Статистик мэдээний тархаалт хийх - Ажилтны эрүүл мэндийн үзлэгийн мэдээлэл оруулах <p>Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуульд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний ажлын тайлан</p> <p>2018-2019 оны хичээлийн жилд Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль нь 33 бүлгийн</p>
--	--	---

		<p>897 хүүхэд ЕБС-д хамрагдаж нийт 77 удирдах ажилтан, багш, бусад ажилтан ажиллаж байна. 2018 оны 12 дугаар сарын 06–ны өдөр тус сургуулийндунд ангийн сургалтын менежер А.Цэнд-аюуш нартай хамтран ажиллалаа.</p> <p>Статистик мэдээ цаасаар хэвлэж гаргасан боловч баталгаажуулж тамга тэмдэг даруулаагүй байна. Мөн мэдээний тархаалт хийх шаардлагатай байна.</p> <p>Боловсролын салбарын мэдээллийн системийн бүртгэлийн хүрээнд:</p> <p>Хүүхдийн холбоо барих утас, гэрийн хаяг, амьдрах орчин, зураг, эрүүл мэнд, дүрэмт хувцас оруулсан боловч баримт бичиг оруулаагүй байна. Ажилтны хүрээнд боловсрол, холбоо барих утас, гэр бүлийн мэдээлэл, багшийн мэргэжлийн бэлтгэл, багшлах эрх зөвшөөрөл, шагнал шийтгэлийн мэдээллийг оруулсан боловч зураг, эрүүл мэнд оруулаагүй байна.</p> <p>Байгууллагын хүрээнд сургуулийн байр болон өрөө анги танхим бүрэн оруулсан байна.</p> <p>Цаашид сайжруулах зүйлс :</p> <ul style="list-style-type: none"> - Статистик мэдээний тархаалт хийх - Ажилтны эрүүл мэндийн үзлэгийн мэдээлэл оруулах - Суралцагчын баримт бичиг оруулах
--	--	---


		<p>- Багш журнал хөтлөлт сайжруулах</p> <p>Мандал сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуульд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний ажлын тайлан</p> <p>2018-2019 оны хичээлийн жилд Мандал сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургууль нь 41 бүлгийн 1298 хүүхэд ЕБС-д хамрагдаж нийт 83 удирдах ажилтан, багш, бусад ажилтан ажиллаж байна.</p> <p>2018 оны 12 дугаар сарын 06–ны өдөр тус сургуулийн дунд ангийн сургалтын менежер Ж.Мягмарсүрэнтэй хамтран ажиллалаа. Статистик мэдээг аймгийн нэгтгэлтэй тулгаж үзэхэд ямар нэгэн зөрүүтэй тоо илрээгүй.</p> <p>Боловсролын салбарын мэдээллийн системийн бүртгэлийн хүрээнд:</p> <p>Хүүхдийн холбоо барих утас, гэрийн хаяг, амьдрах орчин, зураг, эрүүл мэнд, дүрэмт хувцас оруулсан боловч баримт бичиг оруулаагүй байна.</p> <p>Ажилтны хүрээнд боловсрол, холбоо барих утас, гэр бүлийн мэдээлэл, багшийн мэргэжлийн бэлтгэл, багшлах эрх зөвшөөрөл, шагнал шийтгэлийн мэдээллийг оруулсан байна. Байгууллагын хүрээнд сургуулийн байр болон өрөө анги танхим бүрэн оруулсан байна. Анхан шатны бүртгэлийг бүрэн хийсэн нь сайн байна.</p> <p>Цаашид сайжруулах зүйлс :</p>
--	--	--

		<ul style="list-style-type: none"> - Статистик мэдээний тархаалт сайжруулах - Сурагчийн эрүүл мэндийн мэдээлэл оруулах - Статистик мэдээ цаасаар гарсан бол баталгаажуулалт хийх <p>Мандал сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуульд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний ажлын тайлан</p> <p>2018-2019 оны хичээлийн жилд Мандал сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь 37 бүлгийн 964 хүүхэд ЕБС-д хамрагдаж нийт 103 удирдах ажилтан, багш, бусад ажилтан ажиллаж байна. 2018 оны 12 дугаар сарын 06–ны өдөр тус сургуулийн дунд ангийн сургалтын менежер Т.Амарсайхантай хамтран ажилалаа. Статистик мэдээг аймгийн нэгтгэлтэй тулгаж үзэхэд ямар нэгэн зөрүүтэй тоо илрээгүй.</p> <p>Боловсролын салбарын мэдээллийн системийн бүртгэлийн хүрээнд:</p> <p>Хүүхдийн холбоо барих утас, амьдрах орчин, зураг, эрүүл мэнд, баримт бичиг, дүрэмт хувцас оруулсан боловч гэрийн хаяг оруулаагүй байна. Ажилтны хүрээнд боловсрол, холбоо барих утас, гэр бүлийн мэдээлэл, багшийн мэргэжлийн бэлтгэл, багшлах эрх зөвшөөрөл, шагнал шийтгэлийн мэдээллийг оруулсан байна.</p> <p>Байгууллагын хүрээнд сургуулийн байр болон өрөө анги</p>
--	--	---

		<p>танхим бүрэн оруулсан байна. Анхан шатны бүртгэлийг бүрэн хийсэн нь сайн байна.</p> <p>Цаашид сайжруулах зүйлс :</p> <ul style="list-style-type: none"> - Сурагчийн эрүүл мэндийн мэдээлэл бүрэн оруулах <p>Эрүүл мэндийн төвийн шинжилгээ үнэлгээний ажлын тайлан</p> <p>Эрүүл мэндийн төвүүдэд анхан шатны маягт дутуу хөтлөгддөг, эмчийн үзлэгийн бүртгэл хөтлөлт дутуу, их, бага эмч нарын үзлэгийн бүртгэл хөтлөлт хангалтгүй, өвчтөний түүх бичилт дутуу, нас баралтын гэрчилгээний бичилт дутуу үхэлд хүргэсэн шууд шалтгаан, үхлийн үндсэн шалтгаан, үхлийн үндсэн шалтгааныг тодорхой бичээгүй, оношийн кодыг 4 оронгийн түвшинд ашиглаагүй зэрэг нийтлэг алдаа дутагдал гарсан сумдын Эрүүл мэндийн төвүүдэд зөвлөгөө өгч гаргасан алдаа дутагдлыг засч залруулан эргэн мэдээлэх үүрэг өглөө.</p>
Нийт 5 сум	Нийт 7 сургууль, 6 цэцэрлэг, 4 эрүүл мэндийн төв	Нийт хүндрэл, бэрхшээл, зөрчил: 18

1 БУСАД АЖИЛ

- ❖ Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339-р тогтоолоор батлагдсан “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, Сэлэнгэ аймгийн Засаг даргын А/78 дугаар захирамж, аймгийн Онцгой байдлын газар 31/24 дугаартай мэдэгдлийн дагуу орон даяар гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулийг 2018 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 16:00 цагт Сэлэнгэ аймгийн Статистикийн хэлтсийн ажилтан албан хаагчид аюулгүй газарт шилжин байрших дадлага сургууль амжилттай зохион байгуулан ажиллалаа.



- ❖ Аймгийн Засаг даргын 2018 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн дугаар 01 албан даалгавраар төв суурин газарт цэвэр орчин бүрдүүлэх, орчны эрүүл ахуйн байдлыг сайжруулах хог хаягдлыг цэвэрлэх зорилгоор зохион байгуулсан “Бүх нийтийн хог цэвэрлээгээ”-нд 2018 оны 03 дугаар сарын 30-нд төв зам дагуух хогийг цэвэрлэж хэлтсийн нийт албан хаагчид идэвхтэй оролцлоо.



- ❖ Төрийн албан хаагчдын бие бялдрыг хөгжүүлэх, нийтийн биеийн тамирыг дэлгэрүүлэх зорилгоор уламжлал болгон зохион байгуулагддаг “Аймгийн Засаг даргын нэрэмжит” тэмцээнд 2018 оны 04 дүгээр сарын 06-нд хэлтсийн нийт албан хаагчид хурд хүч авхаалж самбаагаа сорин идэвхтэй оролцлоо.

